ГАРЧИГ

НЭГ. ОРШИЛ 6
ХОЁР. СУМЫН ТАНИЛЦУУЛГА, БҮС НУТГИЙН ЧИГ ХАНДЛАГА, ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО 7
2.1. Сумын танилцуулга 7
2.2. Сумын хөгжлийн цогц бодлого (2011-2021 он) 8
2.3. Булган аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 17
ГУРАВ. ГАЗРЫН НӨӨЦ, АШИГЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ 21
3.1. Бэлчээрийн газрын төлөв байдлын үнэлгээ 21
3.2. Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй 24
3.2.1. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ, бэлчээрийн багтаамж ..24
3.2.2. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох. (Хонин сүрэг) 26
3.2.3. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох. (Ямаан сүрэг) 28
3.2.4. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох. (Үхэр сүрэг) 32
ДӨРӨВ. СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ТОХИРОМЖТОЙ БОЛОН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ 35
4.1. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ 35
4.1.1. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ 35
4.1.2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ 52
4.1.3. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ .55
4.1.4. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ 58
4.1.5. Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ 61
4.1.6. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ 64
4.1.7. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ 67
4.2. Орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээ 69
4.2.1. Иргэн, хуулийн этгээд, малчдын хэрэгцээт байдлын үнэлгээ 69
ТАВ. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 72
5.1. Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө 72
5.2. Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө 75
5.2.1. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс 75
5.2.2. Зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүс 78
5.3. Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө 81

5.3.1. Бэлчээрийн газрын төлөвлөгөө....81
5.3.2. Бэлчээрийн ашиглалтын хэсгийн төлөвлөгөө....87
5.3.3. Хадлангийн газрын төлөвлөгөө....91
5.3.4. ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборт газрын төлөвлөгөө....93
5.4. Хот, тосгон бусад суурин газрын төлөвлөгөө....95
5.4.1. Суурин газрын төлөвөгөө....95
5.4.2. Аялал жуулчлалын газрын төлөвлөгөө....97
5.5. Зам, шугам сүлжээний газрын төлөвлөгөө....99
5.5.1. Авто замын газрын төлөвлөгөө....99
5.5.2. Гүүр барих, даваа засах газрын төлөвлөгөө....99
5.6. Тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөө....101
5.7. Зүй ёсны эрхээр ашиглах нутаг дэвсгэрийн төлөвлөгөө....103
ЗУРГАА. ДҮГНЭЛТ....105
АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ....107
ХАВСРАЛТ – 1. ФОТО ЗУРАГ....108

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бэлчээрийн төлөв байдлын ангилал 21
Хүснэгт 2. Бэлчээрийн газрын нийт ургац 24
Хүснэгт 3. Мал бэлчээрээс өдөрт идэх ургац 25
Хүснэгт 4. Нэг хонин толгойн идэх ургац, улирлаар 25
Хүснэгт 5. Нядалгааны гарц тооцох норм 26
Хүснэгт 6. Монгол хонины махны гарц тооцох норм 26
Хүснэгт 7. Хонин сүргийн зохистой харьцаа (2016 оны малын тоо) 27
Хүснэгт 8. Хонины махны ашиг шимийг бий болгох боломж 27
Хүснэгт 9. Хонины сүү бий болгох чадавх 27
Хүснэгт 10. Хонины ноос бий болгох чадавх 27
Хүснэгт 11. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх 28
Хүснэгт 12. Нядалгааны гарц тооцох норм 29
Хүснэгт 13. Ямааны махны гарц, жилийн өсөлт 29
Хүснэгт 14. Ямаан сүргийн зохистой харьцаа (2016 оны малын тоо) 29
Хүснэгт 15. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломж 30
Хүснэгт 16. Ямааны сүү бий болгох чадавх 30
Хүснэгт 17. Ямааны ноолуур бий болгох чадавх 31
Хүснэгт 18. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх 31
Хүснэгт 19. Нядалгааны гарц тооцох норм 33
Хүснэгт 20. Үхрийн махны гарцны норм 33
Хүснэгт 21. Үхэр сүргийн зохистой харьцаа (2016 оны малын тоо) 33
Хүснэгт 22. Үхрийн махны ашиг шимийг бий болгох боломж 33
Хүснэгт 23. Үхрийн сүү бий болгох чадавх 34
Хүснэгт 24. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх 34
Хүснэгт 25. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /өвөл-хавар/ 36
Хүснэгт 26. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /зун-намар/ 44
Хүснэгт 27. Тариаланд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га 53
Хүснэгт 28. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбай 55
Хүснэгт 29. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбай 59
Хүснэгт 30. Авто болон төмөр зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглах газрын тохиромжтой газрын талбай 61
Хүснэгт 31. Ойн сангийн тохиромжтой газрын талбай 65

Хүснэгт 32. Судалгаанд хамрагдсан иргэдийн төлөөлөл 69
Хүснэгт 33. Санал, асуулгын хураангуй 70
Хүснэгт 34. SWOT шинжилгээний үр дүн 71
Хүснэгт 35. Хамгаалалтын бүс 75
Хүснэгт 36. Усны хамгаалалтын бүсүүд, талбай 76
Хүснэгт 37. Зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүс 78
Хүснэгт 38. Бэлчээрийн ашиглалтын улирлын хуваарь, талбай 81
Хүснэгт 39. Улирлын бэлчээр багтаамж, даац 83
Хүснэгт 40. Бэлчээр ашиглалтын хэсгийн багтаамж, даац 87
Хүснэгт 41. Хадлангийн газрын төлөвлөгөө, байршил 91
Хүснэгт 42. ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборт газрын төлөвлөгөө 93
Хүснэгт 43. 95
Хүснэгт 44. Аялалын маршрут 97
Хүснэгт 45. Төлөвлөж буй жуулчны бааз, зогсоолын байршил 97
Хүснэгт 46. Авто замын газрын төлөвлөгөө 99
Хүснэгт 47. Даваа засах, гүүр барих газрын байршил, солбицол 100

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ 23
Зураг 2. Өвөл-хаврын улиралд **адуунд** тохиромжтой бэлчээр 39
Зураг 3. Өвөл-хаврын улиралд хонинд тохиромжтой бэлчээр 40
Зураг 4. Өвөл-хаврын улиралд тэмээнд тохиромжтой бэлчээр 41
Зураг 5. Өвөл-хаврын улиралд үхэрт тохиромжтой бэлчээр 42
Зураг 6. Өвөл-хаврын улиралд ямаанд тохиромжтой бэлчээр 43
Зураг 7. Зун-Намрын улиралд адуунд тохиромжтой бэлчээр 47
Зураг 8. Зун-Намрын улиралд хонинд тохиромжтой бэлчээр 48
Зураг 9. Зун-Намрын улиралд тэмээнд тохиромжтой бэлчээр 49
Зураг 10. Зун-Намрын улиралд үхэрт тохиромжтой бэлчээр 50
Зураг 11. Зун-Намрын улиралд ямаанд тохиромжтой бэлчээр 51
Зураг 12. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ 54
Зураг 13. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ 57
Зураг 14. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ 60
Зураг 15. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ 62

Зураг 16. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ 63
Зураг 17. Ойн сангийн зориулалтын газрын тохиромжтой байдлын үнэлгээ 66
Зураг 18. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ 68
Зураг 19. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө 74
Зураг 20. Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө 80
Зураг 21. Бэлчээр ашиглалтын улирлын төлөвлөгөө 85
Зураг 22. Улирлын бэлчээрийн ашиглалтын даац 86
Зураг 23.Бэлчээрийн ашиглалтын хэсгийн төлөвлөгөө 89
Зураг 24. Бэлчээр ашиглалтын хэсгийн даац 90
Зураг 25. Хадлангийн газрын төлөвлөгөө 92
Зураг 26. ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборт газрын төлөвлөгөө 94
Зураг 27. Хот суурин газрын төлөвлөгөө 96
Зураг 28. Аялал жуулчлалын газрын төлөвлөгөө 98
Зураг 29. Авто замын газрын төлөвлөгөө 100
Зураг 30. Тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөө 102
Зураг 31. Зүй ёсны эрхээр баталгаажуулах төлөвлөгөө 104

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем 35
График 2. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /өвөл-хавар/ 36
График 3. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /зун-намар/ 44
График 4. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд 53
График 5. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний үзүүлэлт 55
График 6. Шинээр байгуулах хот, суурин газарын тохиромжтой байдлын үнэлгээ 56
График 7. Ландшафтын үнэлгээний схем 59
График 8. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ 61
График 9. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ 65
График 10. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний үндсэн чиг хандлага 72
График 11. Бэлчээрийн ашиглалтын улирлын хуваарь, эзлэх хувь 82
График 12. Улирлын бэлчээрийн даац 84

НЭГ. ОРШИЛ

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах ажлын гол зорилго нь Булган аймгийн Сэлэнгэ сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар болон байгалийн нөөц нөхцөлийг зүй зохистой ашиглуулах боломжийг судалсны үндсэн дээр газрын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилсан, нутаг дэвсгэрийн цаашдын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад оршино.

МУ-ын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, салбарын норм дүрэм, “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Сумын хөгжлийн цогц бодлого 2016-2021 он”, “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГЗБГЗЗГазар, “Монголын Газар Зохион Байгуулагчдын Холбоо”-ны хамтран боловсруулсан “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” зааврын дагуу **“Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”**-г газрын мэргэжлийн “Вектор Мэп” ХХК хийж гүйцэтгэлээ.

Төслийн нэр:	Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө
Төслийн зорилго:	Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар болон байгалийн нөөц нөхцөлийг зүй зохистой ашиглуулах боломжийг судалсны үндсэн дээр газрын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилсан, нутаг дэвсгэрийн цаашдын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад оршино.
Төслийн байршил:	Сэлэнгэ сумын нийт нутаг дэвсгэр
Төслийн хэмжээ:	484.7 мянган га талбай
Төсөлд хамрагдах олон нийт:	1035 өрхийн 3306 хүн амтай

ХОЁР. СУМЫН ТАНИЛЦУУЛГА, БҮС НУТГИЙН ЧИГ ХАНДЛАГА, ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО

2.1. Сумын танилцуулга

Булган аймгийн Сэлэнгэ сум нь Улсын тэргүүний сум.

Тус сум нь 1943 онд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхээр МААМС-ын суурин дээр Ингэттолгой САА нэртэйгээр байгуулагдсан. Булган аймгийн Хөдөлмөрчдийн депутатын хурлын тэргүүлэгчдийн 1959 оны 03-р сарын 02-ны өдрийн 07 тоот тогтоолоор сум байгуулахаар өргөн мэдүүлж, Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1959 оны 08-р сарын 29-ний өдрийн 129 дүгээр тогтоолоор Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн хуваарилалт хийхэд тэр үеийн Цонхлон сумын 3, 4-р баг, Сэлэнгэбүрэн сумын 2, 3, 4-р багуудыг нэгтгэн 482952 га нутаг дэвсгэрт 404 өрх, 1800 хүн ам, 30571 толгой малтай байгууллагджээ. 1984 онд батлагдсан өндөр ашиг шимт Сэлэнгэ үүлдрийн үхрийг өсгөн үржүүлэх цөм сүргийн Сэлэнгэ төвийн үйл ажиллагаа нь өсвөр үхрийг үржүүлж үүлдэр угсаа сайжруулагчаар ашиглахад чиглэгдэж байна.

Тус сум нь хойд талаараа ОХУ-ын Буриад улс, Булган аймгийн Тэшиг сумтай 200 гаруй км, зүүн хойд болон зүүн талаараа Сэлэнгэ аймгийн Түшиг, Цагааннуур сумуудтай, зүүн урд талаараа Булган аймгийн Хангал сумтай, баруун болон баруун хойд талаараа Булган аймгийн Бугат, Хутаг-Өндөр сумуудтай хиллэнэ.

2015 онд БХБЯ-ны ГХГЗЗГ-ын захиалгаар хийж гүйцэтгэсэн “МУ-ын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгийг солбицолжуулах, баталгаажуулах ажил”-ын үр дүнд тус сум нь 484.8 мянган га газар нутагтай гэж бүртгэгдсэн байна.

Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрт Сэлэнгэ мөрөн, Зэлтэрийн голын ай савын 100 гаруй горхи, булаг шанд байдаг. Нутгийн хамгийн өндөр цэг нь Монгол улс, ОХУ-ын хилийн заагт байдаг далайн түвшнөөс дээш 2027 метр өргөгдсөн Сарьдаг уул, хамгийн нам дор газар нь далайн түвшнөөс дээш 700 метр өргөгдсөн Ингэттолгой болно.

Нийт нутгийн 75-78 хувийг ой мод эзэлж, хуш, хар мод, нарс, улиас зэрэг 10 гаруй модлог ургамал ерхөг согоовор, хялгана зэрэг өвслөг болон эмийн ургамал, самар, аньс, нэрс, мойл, гүзээлзгэнэ зэрэг жимс элбэг ургадаг. Баавгай, гахай, буга, согоо, шилүүс,

нохой зээх, хүдэр зэрэг ан амьтад олонтой, тул, зэвэг зэрэг 10 гаруй нэр төрлийн загас жараахайтай. Дух нарс, Талын хайлаас, Эг-Сэлэнгэ голын бэлчир, Далхабандида, Эхийн умай зэрэг түүх соёлын дурсгалт газрууд олонтой нутаг юм.

Нийт нутаг дэвсгэрийн 49.4 хувийг улсын тусгай хамгаалалттай газар нутаг эзэлнэ.

2017 оны байдлаар 1035 өрхийн 3306 хүн амьдардаг. Нийт хүн амын 67.4 хувь нь 0-35 насны залуучууд, 49.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Таримал, Тариахтай, Сэлэнгэбүрэн, Атар, Ингэт гэсэн засаг захиргааны 5 багтай. Сумын хэмжээнд нийт малчин, мал бүхий 314 өрхийн 90796 толгой малтай.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон, 6 сувгийн телевизийн антен, суурин утасны Инкомнет антен, үүрэн холбооны Скайтел, Мобиком, Юнителийн сүлжээнд холбогдсон.

2017 оны байдлаар эрүүл мэндийн байгууллага нь 9 ортой, их эмч 3, сувилагч 5, эх баригч 1, багийн эмч 3, бага эмч 2, лаборант нэгтэй ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн хувьд 23 бүлэгтэй үүнээс бага боловсролын 14, суурь боловсролын 4, бүрэн дунд боловсролын 5 бүлэг, нийт 415 суралцагсад байгаагаас бага боловсролд 205, суурь боловсролд 111, бүрэн дунд боловсролд 99 сурагч байна. Нийт 28 багштайгаас бага боловсролын 10, суурь боловсролын 10, бүрэн дунд боловсролын 8 багштай, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 221 хүүхэд суралцаж байгаагаас цэцэрлэгийн хүүхэд 178, хувилбарт сургалтанд 43 хүүхэд, малчны хүүхэд 56, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 2 байна. Нийт 29 ажилчин, албан хаагчтайгаас эрхлэгч 1, арга зүйч 1, үндсэн багш, туслах багш 7, бусад ажилчид 12 байна.

Тус сумын тэргүүлэх салбар нь газар тариалан бөгөөд “Ингэттолгой” ХК, “Интосэ” ХХК, “Хастав” ХХК, “Оргилдэлгэр” ХХК, “Өрмөгтэй” ХХК зэрэг ААН-үүд парк шинэчлэл хийж, 14.3 мянган га талбайд тариалан эрхэлж байна.

2.2. Сумын хөгжлийн цогц бодлого (2011-2021 он)

1. **Хөгжлийн алсын хараа.** Хүний хөгжил, орон нутгийн боломж, нөөцөд түшиглэн өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, олон талтай мэдлэгт суурилсан эдийн засгийн өсөлтийг хангах замаар, өрх бүр орлоготой байх нөхцөл хангагдсан тэргүүний сум болоход оршино.
2. **Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд**
   a. Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ.

b. Гадаад болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай, хувийн хэвшилд тулгуурласан үйлдвэрлэл, түүний дотор Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрчимтэй хөгжүүлж, сумын эдийн засгийг олон талтай, мэдлэгт суурилсан баазтай болгоно.
c. Холбоо мэдээлэл, зам гүүр, эрчим хүч, барилга байгууламжийг хөгжүүлэн өргөжүүлж амьдралын таатай орчин бүрдүүлнэ.
d. Сумын төв, багийн төв болон айл өрх, малчдын хотхоны тохижилтыг сайжруулна.
e. Байгалийн нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэлийг дэмжиж, хамгаалахад суурилсан аялал жуулчлалын салбарыг сумын эдийн засгийн голлох салбарын нэг болгон хөгжүүлнэ.

3. Нийгмийн хөгжлийн цогц бодлого. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого.

Зорилт 1. Хүний хөгжлийг бүх талаар дэмжих, 96-аас доошгүй ядуу өрхийн амьжиргааг тогтвортой дээшлүүлж, 500-аас доошгүй байнгын болон улирлын ажлын байр бий болгох, ажилгүйдлийн түвшинг 6 хувь хүртэл бууруулах, нийгмийн баялгийг бүтээхэд оролцдог иргэдийн тоог өсгөх.

Зорилт 2. Хүн амыг тогтвортой ажлын байраар ханган орлогын байнгын эх үүсвэрийг нэмэгдүүлснээр ажилгүйдлийг тууштай бууруулна.

Зорилт 3. Ядуурлыг бууруулахад иргэд, аж ахуй нэгж байгууллагын тэгш оролцоог хангана.

4. Хүн ам зүй, нийгмийн хамгааллын бодлого

Зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг тууштай нэмэгдүүлнэ.

Зорилт 2. Нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулан иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгоно.

Зорилт 3. Гэр бүл нийгмийн бүлгүүдийн аж байдлыг сайжруулах цогц арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

Зорилт 4. Хүн амын жилийн дундаж өсөлтийг аймгийн дундаж түвшинд хүргэх

Зорилт 5. Хүнийг хөгжүүлэх боломжийг бүрэн дүүрэн ашиглах замаар хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг аймгийн дундаж түвшинд хүргэх.

Зорилт 6. Нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг боловсронгуй болгоно.

5. Боловсролын талаарх бодлого

Зорилт 1. Суурь ба бүрэн дунд боловсролын хамран сургалтын хүрээг нэмэгдүүлэх, өөрийн болон улсын төсвийн нөөц бололцоонд тулгуурлан сургалтын орчинг шинэчлэх, тохижуулах.

Зорилт 2. Багшлах боловсон хүчний нөөц, мэргэжил, арга зүйн ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх нийгмийн асуудалд анхаарч, шинэ залуу багш нарыг орон байраар хангах ажилд дэмжлэг үзүүлэх.

Зорилт 3. Боловсролын стандарт, нэгж хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, түүнийг дэмжих орчин үйл ажиллагааг үнэлэх.

Зорилт 4. Сурах бичгийн хангамжийг сайжруулах, номын санг автоматжуулалтын системд шилжүүлэх, Цахим номын сан- мэдээллийн төв болгох.

6. Сургуулийн Өмнөх Боловсрол

Зорилт 1. Сургуулийн өмнөх боловсролын бодлого зохицуулалт, менежментийн тогтолцоог сайжруулах.

Зорилт 2. Сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтын агуулгын стандартыг мөрдөх түүний шаардлагыг хангахуйц сургалтын технологын шинэчлэл хийх.

Зорилт 3. Хүүхэд хамгаалах түүнтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаанд эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

Зорилт 4. Сургалтын орчны шаардлагыг өндөр түвшинд хангах материаллаг баазыг бэхжүүлэх.

Зорилт 5. Боловсон хүчний төлөвлөлт хийх мэргэшүүлэх чадавхыг дээшлүүлэх

7. Эдийн засгийн бодлого

<u>Нэгдүгээр үе шат (2011-2015 он):</u>

- Сумдыг бүсчлэн хөгжүүлж, бичил бүсүүдийг эдийн засгийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлснээр хойд бүсэд газар тариалан, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх, ОХУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох, урд бүсэд Улаанбаатар хот болон томоохон суурин газрыг мах, сүүгээр хангахад

чиглэгдсэн үйлдвэр хөгжүүлэх, Хангайн бүсийн болон төвийн аймгуудад малын тэжээл нийлүүлэх, зүүн бүсэд аймгийн болон хангайн бүсийн аймгуудыг гурилаар хангах, төвийн бүсэд Орхон аймаг болон аймгийн төвийг мах, сүү, төмс болон хүнсний ногоогоор хангах, барилгын материалын үйлдвэрлэл хөгжүүлэх.

- Мал аж ахуйн түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах жижиг дунд үйлдвэрийг байгуулах.
- Түүхий эдийн арвин нөөцдөө тулгуурлан барилгын материалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
- Газар тариалан болон мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.
- Аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх салбар болгох.
- Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэх.
- Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого барьж ажиллах.
- "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг өрнүүлж, баг тус бүр өөрийн нэрийн чанар сайтай, брэнд" бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
- Бөөний худалдааны төв бий болгох.

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

- Аялал жуулчлалыг сумын эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох.
- Хувийн хэвшилд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах.
- Боловсруулах аж үйлдвэр чацаргана, газар тариалан, мал аж ахуйн фермер, хоршоо, үйлдвэрлэл үйлчилгээний салбар хөгжсөн эдийн засгийн бүтцийг бий болгох;
- Хөдөө аж ахуйн экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх.

8. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

Бүх үе шат (2011-2021 он):

- Махны чиглэлийн загвар аж ахуй байгуулж мал бордох, мах боловсруулах үйлдвэрийн цогцолбор болгон өргөжүүлэх.

- Гурилын үйлдвэрийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж тоног төхөөрөмж, технологийг шинэчилэх, жижиг үйлдвэр байгуулах замаар Орхон, Булган аймгууд болон сумын гурилын дотоодын хэрэгцээг гурилаар хангах.
- Сүү цагаан идээ боловсруулах орчин үеийн технологи бүхий үйлдвэр байгуулах.
- Хүнсний үйлдвэр болон жимс, жимсгэнэ, хүнсний ногоог дахин боловсруулах үйлдвэр байгуулах.
- Шахмал түлшний үйлдвэр байгуулах.
- Ахуй үйлчилгээний төв байгуулах.
- Хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулах.
- Байгалийн цэвэр ус савлах цех байгуулах.
- Зөгийн аж ахуй болон мах, сүү, гурил, жимс жимсгэнэ, арьс шир, ноос боловсруулах жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх.
- Гахайн фермерийн аж ахуйг хөгжүүлж утсан гахайн махны ЖДҮ-лэл бий болгох.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэгдсэн бирж байгуулах.
- Бөөний худалдааны сүлжээнд түшиглэн мах, ноос ноолуур, арьс ширийг стандартын дагуу бэлтгэх, тэдгээрийг дотоодын үйлдвэрүүдтэй хоршин боловсруулах чиглэлийн ЖДҮ байгуулах.
- Төмс хүнсний ногоо боловсруулах болон шарсан төмсний үйлдвэр байгуулах.
- Элит болон нутагшсан монгол сортын үрийн нөөц бүрдүүлэх.
- Чацаргана боловсруулах ЖДҮ байгуулах.
- Шим бордоо үйлдвэрлэх ЖДҮ байгуулах.
- Загасны аж ахуй хөгжүүлж, утсан загасны жижиг дунд үйлдвэрлэл бий болгох.
- Байгальд халгүй байгалийн дагалдах баялаг ашиглах жижиг дунд үйлдвэрлэл бий
- болгох.
- Төрийн байгууллагуудаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, иргэдэд үзүүлэх үйлчилгээг “нэг цэг” зарчимд шилжүүлэх.
- Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг мэдээллээр хангах, техник, технологийн сонголт хийх, төсөл боловсруулахад зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх.
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн түрээсээр (лизингээр) тоног төхөөрөмж олгох үйлчилгээг хөгжүүлэх.

9. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого

<u>Бүх үе шат (2011-2021 он):</u>

- Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулах.
- Газар тариалан, мал аж ахуй хосолсон үхрийн эрчимжсэн фермерийн загвар аж ахуй байгуулах санаачилгыг дэмжих.
- Өрхийн аж ахуйг хоршсон хэлбэрт шилжүүлэх.
- Бог будааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж гадаадад экспортлох, томоохон үйлдвэрлэл бий болгох.
- Мал эмнэлэг, үржлийн алба, үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлэн, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангах.
- Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг худаг, уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд урт хугацааны гэрээгээр эзэмшүүлэх.
- Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар бэлчээрийн багтаамж, даацыг нэмэгдүүлэх.
- Ашиглагдахгүй байгаа бэлчээрт худаг гаргах, хурын ус хуримтлуулах, булаг шандны усыг хамгаалах замаар усжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх.
- Малчдын ундны усны хүрэлцээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах.
- Гүн хөлдөөсөн үрийн цэг байгуулах;
- Өндөр ашиг шимтэй махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхрээр нутгийнхаа мал сүргийг сайжруулах.
- Мах, сүүний чиглэлээр эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал эмнэлгийн лаборатори байгуулах.
- Отрын болон нөөц бэлчээрт уст цэгийн хайгуул судалгаа хийж, жилд 3-аас доошгүй худаг шинээр гаргах.
- Аж ахуйн нэгжийн хөрөнгөөр гүний худаг, малчид, иргэдийн хүчээр баг бүрт гар худаг гарган бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх.
- Тэжээлийн цех ажиллуулах.
- Малчдын экологийн хувьд цэвэр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээг Эрдэнэт хотод байгуулах

10. Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжлийн бодлого

<u>Бүх үе шат (2011-2021 он):</u>

- Худалдаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

- Сумын худалдаа, үйлчилгээний салбарын чанар, хүртээмжийг аймаг, хот буюу төвлөрсөн газруудын үйлчилгээний цэгийн түвшинд ойртуулах.
- Худалдаа үйлчилгээний бөөний төв болон зочид буудал, зоогийн газрын үйлчилгээтэй болох.
- Худалдаа, үйлчилгээний ажилтнуудыг сургах, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх.
- Худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллагууд, иргэдийн зүгээс тавих хяналтыг сайжруулах.
- Худалдаа, үйлчилгээний салбарт стандарт, норм, нормативыг мөрдүүлэх.
- Иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн худалдаа, үйлчилгээний газруудыг хүчин чадал, үйлчилгээний нэр төрлөөр нь зохистой байршуулах.

11. Дэд бүтцийн хөгжлийн бодлого

Бүх үе шат (2011-2021 он):

- Орон нутгийн замуудыг сайжруулан засварлах.
- Авто замын салбарыг хөгжүүлэхэд орон нутагт ажиллаж амьдарч буй иргэдийн оролцоо дэмжлэг, байгалийн баялаг, нөөцөд түшиглэн үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ийн хандив тусламж орон нутгийн төсөв, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд, төрийн бус байгууллагуудын хамтын оролцоотойгоор орон нутгийн замаа сайжруулна.
- Сэлэнгэ сумаас Орхон аймаг хүртэлх авто замын сүлжээг шинэчлэн тогтоож засварлана.
- Хөдөөгийн зарим голын гүүрийг засварлах, шинээр барих.
- Сумын төв, 2-р багийг холбосон явган хүний гүүртэй болох
- "Буман нарны гэр" хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Сумын төвийн гудамж хороодыг шөнийн гэрэлтүүлэгтэй болгох.
- Сумын төвийн 1, 5-р багийн иргэдийг ундны цэвэр усаар хангах.
- Хөдөөгийн багуудын 0.4 квт-ын шугамыг шинэчлэх
- Айл өрхүүдийн цахилгааны шон, агаарын шугамыг бүрэн шинэчлэх.
- Сумын төвийн нэгдсэн халаалтын шинэ системийн хүчин чадлыг бүрэн ашиглаж төр төсвийн байгууллагууд, айл өрхийн хувийн орон сууц, үйлдвэр үйлчилгээний барилгуудыг дулааны нэгдсэн сүлжээнд холбоно.
- Өндөр хурдны шилэн кабелд холбогдож интернеттэй болох.

- Интернет цэг, интернет кафе байгуулж иргэдэд үйлчлэх.
- 10-с доошгүй сувгийн телевизийн нэвтрүүлэг үзэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Мэдээлэл харилцаа холбооны технологийн өндөр ур чадвартай мэргэжлийн боловсон хүчинг төрийн бодлогоор орон нутгаас бэлтгэнэ.
- Мэдээллийн төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх.
- Электрон арилжаа, электрон үйлчилгээ зэрэг шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх.

12. Байгаль орчны бодлого

Зорилт 1. Байгаль орчны доройтлыг сааруулна.

Зорилт 2. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилт 3. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулж экологийн тэнцвэрт байдлыг хадгална.

Зорилт 4. Амьтан, ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлах, тэдгээрийг байгалийн жамаар нөхөн сэргээх, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

13. Аялал жуулчлал, Газрын харилцааны бодлого

<u>Бүх үе шат (2011-2021 он):</u>

- Газар ашиглалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.
- Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн аж ахуйн нэгж, иргэдийн газар ашиглалт сайжирч усалгаатай тариалангийн талбайг жил бүр нэмэгдүүлж, га-аас авах ургац, сэлгээнд тариалах ургамлын тоо нэмэгдсэн байх.
- Сэлэнгэ мөрний дагуу Эг-Сэлэнгийн бэлчир, Дух Нарс, Валын хад зэрэг байгалийн цогцолбор газруудад спорт-усан аялалын маршрут гарган аялал жуулчлалын баазуудыг бий болгох.
- Сурагчдын зуны амралт, сургалтын зориулалтаар Могойн ам, Ингэтийн голын Дээд Бэрхд хүүхдийн зуслан байгуулах.
- Атаршсан талбайг эргэлтэнд оруулж жимс жимсгэний тариалалтийг нэмэгдүүлнэ.

- Атаршсан тариалангийн талбайд нөхөн сэргээлт хийх, тарилангийн эргэлтэнд оруулах боломжгүй талбайд олон наст ургамлын үр тарих, бэлчээрт шилжүүлэх.
- Тариалангийн талбайг салхины элэгдлээс хамгаалах зорилгоор ойн зурвас байгуулах.
- Зуслангийн зориулалтаар Ингэтийн гол, Бухын даваа, Баянцагаан, Зуны голын эх зэрэг газарт газар олголт хийж иргэдийн газар өмчлөлд олгуулсан байх.
- Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр газар өмчлөх иргэний газрын дэд бүтэцийн асуудлыг шийдвэрлэсэн байх.
- Газрын шинэтгэлийг эрчимжүүлэх, газрыг иргэн бүрт үнэгүй өмчилж, эдийн засгийн эргэлтэд оруулах;
- Газрын доройтолд орж эвдэрч талхлагдсан газрыг нөхөн сэргээж сайжруулах ажлын хүрээнд ашиг хүртэгч өрхийн тоо нэмэгдсэн байх.
- Үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүрэн хамруулах.

14. Нутгийн удирдлагын бодлого

Зорилт 1. Нутгийн өөрөө удирдах байгууллага, захиргааны байгууллагын шийдвэр гаргах, үйл явцын ил тод байдал, түүнд иргэд оролцох боломжийг хангана.

Зорилт 2. Төрийн үйлчилгээг иргэдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Зорилт 3. Иргэдийн ая тухтай амьдрах орчин, нөхцөлийг хангаж, түүнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

15. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн

- 2011-2021 оны эцэст бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгцээ үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, эдийн засгийн бүтцэд аж үйлдвэрийн эзлэх байр суурь сайжирна.
- Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл жигдэрч сайжирсан байна.
- Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлснээр малын үүлдэрлэг чанар сайжирч, ХАА-н салбарын үйлдвэрлэл хөгжинө.
- Чацарганы боловсруулах үйлдвэртэй болно.
- Байгальд хор нөлөөлөлгүй байгалийн дагалдах баялаг боловсруулах цех, үйлдвэрлэлтэй болно.

- Төмс, хүнсний ногоог боловсруулах эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг бий болсон байна.
- Аялал жуулчлалыг хөгжүүлсэн байна.
- Мал аж ахуй, газар тариалан хослон эрхлэх аж ахуй нэгж, хоршоо, бүл, өрхүүд бий болсноор иргэдийн ажлын байр тоо нэмэгдэж таатай амьдрах орчин нөхцөл бүрдэнэ.

16. Сумын хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх талаар

Булган аймгийн хөгжлийн цогц бодлогыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрүүд, Засаг даргын мөрийн хөтөлбөр болон энэ баримт бичгийн хүрээнд боловсруулах дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, төслүүдэд тусган хэрэгжүүлнэ.

Сумын хөгжлийн цогц бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт, шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаварыг үнэлэн дүгнэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна.

- I үе шат. Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдөр)
- II үе шат. Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр)
- Хяналт, шинжилгээ, үнэлгээг сумын төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр хийж, хяналт, шинжилгээ тасралтгүй явагдана.

2.3. Булган аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-ын бодлого шийдвэрийг хэрэгжүүлж “Хүний төлөө ЭДИЙН ЗАСАГ”-ийг цогцлоож, “Хөгжлийн төлөө ЗӨВ бодлого” барьж ажиллахад оршино. Булган аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн гол онцлог нь:

- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг аймгийнхаа онцлогт тохируулан боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх өндөр чадавхтай, зөв зохион байгуулалттай, хариуцлагатай удирдлагын тогтолцоог бүрдүүлэх
- Боловсрол, соёл, уламжлалт зан заншил, хөдөлмөрч уламжлалыг дээдлэн, хөгжлийн тулгуур хүн, өрх гэр бүлийг хөгжүүлэх.

- Аймаг, сумын хөгжил, айл өрхийн амьдралын түвшинг дээшлүүлж, ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах ХҮН-НИЙГМИЙН ХӨГЖИЛ Гэр бүлийг дэмжих, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, иргэдийнхээ амьжиргааг сайжруулна.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийн хүрээнд:

- Эдийн засгийн өсөлтийг дэмжин, технологийн дэвшилд суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлж, баялгийг бүтээн орлогыг нэмэгдүүлж, сэтгэл хангалуун, аз жаргалтай амьдралыг хамтдаа бүтээнэ.
- Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон, байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, дэвшилтэт технологид суурилсан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бэлчээр, тариалангийн талбайг нөхөн сэргээх, малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг шинэ шатанд хүргэнэ.
    - Малын үржлийн ажил, үйлчилгээ, малын чанарыг сайжруулах замаар эдийн засгийн өсөлтийг хангана.
    - Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ.
    - Хөдөөгийн иргэдийн хөдөлмөр, хөрөнгөөрөө хоршин ажиллаж, орлогоо нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.
    - Мал эмнэлгийн үйлчилгээний олон улсын жишиг, стандартын шаардлагад нийцсэн, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангасан тогтолцоог бүх шатанд бүрдүүлж, мал эмнэлгийн нэгжүүдийг чадавхжуулж, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлж, халдварт өвчингүй тайван байх нөхцөлийг хангана.
    - Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, усалгаатай талбайг нэмэгдүүлэн, эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах замаар тогтвортой ажлын байр бий болгоно.

Байгаль орчин, ногоон хөгжил:

- Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, хүрээлэн буй орчны доройтлыг бууруулан, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлж, эрүүл, аюулгүй, ногоон хөгжлийг бий болгон, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, байгаль хамгаалах үүргийг бүх нийтийн үйл хэрэг болгоно.
    - 2.4.1 Байгалийн нөөц, түүний нөхөн сэргэх чадвар, хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгмийн дэвшлийг түргэтгэх шаардлагатай уялдуулан дасан зохицох, нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, орчны бохирдлыг арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
    - 2.4.2 Усны нөөцийг хэмнэх, хуримтлуулах, зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангана.
    - 2.4.3 Ойн нөөцийн менежментийг сайжруулж, зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
    - 2.4.4 Цөлжилттэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулах, хортон мэрэгчидтэй тэмцэх, усжуулах, байгалийг аясаараа нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлнэ.
    - 2.4.5 Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, газар болон газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
    - 2.4.6 Амьтан, ургамлын удмын санг хамгаалж, нөхөн сэргээх замаар өсгөн үржүүлэх, үр өгөөжийг дээшлүүлнэ.
- Аялал жуулчлалыг эдийн засгийн үр өгөөжтэй, байгальд ээлтэй салбарын нэг болгон хөгжүүлнэ.
    - Аялал жуулчлалын менежментийг сайжруулж, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх арга хэмжээ авна.

Бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, бодлого

2001 онд УИХ-аас Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлан гаргасан. 2007 онд болсон Төвийн бүсийн зөвлөгөөнөөс тус бүсийг эрдсийн баялгийн үлэмжхэн нөөц, үйлдвэрлэлийн болон оюуны чадавх, зам харилцааны давуу талд түшиглэн Монгол улсын цаашдын хөгжлийн тулгуур бүс нутаг болгох зорилт

дэвшүүлсэн. Төвийн бүсийг бүхэлд нь худалдаа эрчим хүч, тээвэр, мэдээллийн технологи, эрдсийн гаралтай бүтээгдэхүүний экспортын үйлдвэрлэл бүхий улс орны хөгжлийн таталцлын гол төв, улс хоорондын тээвэр-хөгжлийн коридор болгох зорилго тавьсан байдаг. Монгол улсын Мянганы Хөгжлийн Зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, аймгийн хөгжлийн бодлого болон засаг даргын /2016-2020 /мөрийн хөтөлбөрийг бодлогын чиг хандлага болгон сум хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулав.

Түүнчлэн Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт болон хөтөлбөрт тусгагдсан аймгийн эдийн засгийн бодлогын баримт бичгийн хүрээнд асуудлыг тусгасныг сумын хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэл болгож байна. Үүнд: тогтвортой эдийн засаг, орон нутгийн хөгжлийн бодлого, Хөдөө аж ахуйн бодлого шинэчлэлийн хүрээнд Булган аймгийг эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг болгоно.

ГУРАВ. ГАЗРЫН НӨӨЦ, АШИГЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

3.1. Бэлчээрийн газрын төлөв байдлын үнэлгээ

Булган аймгийн Сэлэнгэ сумын бэлчээрийн газрын төлөв байдлыг ангилахдаа 2009 оны ГХБГЗЗГ-ын даргын тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах журам”-ын дагуу хийж гүйцэтгэжээ.

Тус суманд дундаж уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээрийн бэлчээр 4474.6 га, уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр 22384.7 га, уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр 15227.0 га, уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нугын бэлчээр 12734.7 га, тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээрийн бэлчээр 18402.3 га, голын хөндийн нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр 30956.0 га тус тус байна.

Хүснэгт 1. Бэлчээрийн төлөв байдлын ангилал

№	Бэлчээрийн ангилал	Талбай /га/
1	Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр	4474.6
2	Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр	22384.7
3	Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр	15227.0
4	Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга	12734.7
5	Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр	18402.3
6	Голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр	30956.0

Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээрийн бэлчээрт Хиаг- алаг өвст, Дэгнүүлт үетэнт, Бутнуур- улалж -алаг өвст, Ботууль- алаг өвст- улалжит, Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст, Хялгана - алаг өвст ургамлын бүлгэмдэлүүд хам байдлаар тархсан байна.

Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст, Ботууль - алаг өвст, Сөөг бүхий Алаг өвс – үетэнт бүлгэмдэлүүд хам байдлаар тархсан байна.

Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр Ботууль – хялганат, Хялгана - үетэнт бүлгэмдэл тархан.

Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нугын бэлчээрт Хиагт, Хиаг - алаг өвст, Үетэн - улалж - алаг өвст, Алаг өвс-улалж – үетэнт ургамлын бүлгэмдэл голлон тархана.

Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээрийн бэлчээрт Хиаг- хазаар өвст, Хиаг- дэрст, Дэгнүүлт үетэнт, Ботууль-жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, Ботууль-хялганат, хялгана-ботуульт, Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, Хялгана-хиагт, Хялгана-хазаарт, Хялгана-дааган сүүлт, Хялгана-биелэгт, Хялгана-монгол өвст, Хялганат, хялгана-алаг өвст, Хялгана-зүр өвст, Жижиг дэгнүүлт үетэнт, Жижиг дэгнүүлт үетэн-хиагт, Жижиг дэгнүүлт үетэн-хялганат, Биелэг-үетэнт, Биелэг-хиагт зэрэг ургамлын бүлгэмдлүүд тархана.



Зураг 1. Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ

3.2. Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй

Бэлчээрийн газрын суурь үнэлгээг тооцохын тулд эхлээд дараах 3 үнэлгээг тодорхойлно. Үүнд:

1. Хөрсний чанарын үнэлгээ /$Х_{чү}$/
2. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ /$БГ_{бчү}$/
3. МАА үйлдвэрлэлийн бизнес тооцооллын аргаар үнэлсэн үнэлгээ /$О_{кү}$/

Дээрх 3 үнэлгээний нийлбэрээр бэлчээрийн газрын суурь үнэлгээ /$Г_{сү}$/-г тооцно. Үүнд:

$$\mathbf{Г_{сү}=Х_{чү}+БГ_{бчү}+МАА_{б}}$$

3.2.1. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ, бэлчээрийн багтаамж

Малд идэгдэх бодит ургацыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

$$\boldsymbol{x1} = \frac{\text{в} * \text{а}\mathbf{1^2}}{\text{а}\mathbf{1^2} + \text{а}\mathbf{1} * \text{а}\mathbf{3} - \text{а}\mathbf{1} * \text{а}\mathbf{2}}$$

- x1 – Малд идэгдэх бодит ургац, цн
- в – Бэлчээрийн газрын нийт ургац, цн
- а1 – нэг хонин толгойд идэгдэх ургац /Зун/
- а2 – нэг хонин толгойд идэгдэх ургац /Намар/
- а3 – нэг хонин толгойд идэгдэх ургац /Өвөл, хавар/

Сэлэнгэ сумын Бэлчээрийн газрын нийт ургац (в)-ыг баг тус бүрээр дараах хүснэгтэд үзүүлэв /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Бэлчээрийн газрын нийт ургац

№	Багийн нэр	Бэлчээрийн талбай /га/	1 га-гийн ургац /цн/	Нийт ургац /цн/
1	Таримал	48847.1	4.5	219812.0
2	Тариахтай	58687.2	5.3	311042.2
3	Сэлэнгэбүрэн	55565.0	4.6	255599.0
4	Атар	34849.8	4.2	146369.2
5	Ингэт	44591.5	4.4	196202.6
Нийт		**242540.6**	**-**	**1129024.9**

Бэлчээрийн газрын нийт ургацыг мал жилийн 4 улиралд идэх бөгөөд ургац зун ногоон, намар хагдарч эхлэх, өвөл, хавар хагд байдлаар малд идэгддэг.

Тиймээс нэг хонин толгойн жилд идэх ургацыг дараах байдлаар тооцно. Үүнд:

$$\mathbf{a1} = \frac{\text{Н}*\text{НМз}}{\mathbf{100}}, \quad \text{а}\mathbf{2} = \frac{\text{Н}*\text{НМн}}{\mathbf{100}}, \quad \text{а}\mathbf{3} = \frac{\text{Н}*\text{НМөх}}{\mathbf{100}},$$

- **a1** – нэг хонин толгойд идэгдэх ургац /Зун/
- **a2 –** нэг хонин толгойд идэгдэх ургац /Намар/
- **a3 –** нэг хонин толгойд идэгдэх ургац /Өвөл, хавар/
- **Н** – ногоон масстай байх хоногийн тоо
- **НМ** – мал бэлчээрээс нэг өдөрт идэх өвс, кг

Мал бэлчээрээс өдөрт идэх ургацын нормыг малын төрлөөр болон улирлаар дараах хүснэгтэд үзүүлэв /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Мал бэлчээрээс өдөрт идэх ургац

Малын төрөл	**Улирал ба өвсний хэмжээ /кг/**			
	Зун	**Намар**	**Өвөл**	**Хавар**
Адуу	7.8	8.1	6.5	5.8
Тэмээ	14.1	13	8.4	9.9
Үхэр	8.7	9.7	7.4	7.4
Хонь	1.9	1.6	1.1	1.1
Ямаа	1.3	1.4	1	1

Ногоон масстай байх хоногийн тоог зуны улиралд 100, намрын улиралд 35, өвөл, хаврын улиралд 230 хоног байхаар тооцсон.

Нэг хонин толгойн идэх ургацын хэмжээг улирал тус бүрээр тодорхойлсныг дараах хүснэгтэд үзүүлэв /Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Нэг хонин толгойн идэх ургац, улирлаар

Улирал	Ногоон масстай байх хоногийн тоо	Нэг хонин толгойн нэг өдөрт идэх өвс, кг	Нэг хонин толгойн идэх ургац, цн	
Зун	100	1.9	**1.9**	**a1**
Намар	35	1.6	**0.56**	**a2**
Өвөл, хавар	230	1.1	**2.53**	**a3**

Малд идэгдэх бодит ургацыг дараах байдлаар тооцно. Үүнд:

$$\boldsymbol{x1} = \frac{\text{в} * \text{а}\mathbf{1^2}}{\text{а}\mathbf{1^2} + \text{а}\mathbf{1} * \text{а}\mathbf{3} - \text{а}\mathbf{1} * \text{а}\mathbf{2}} = \frac{\mathbf{1129024.9 * 3.61}}{\mathbf{3.61 + 4.81 - 1.06}} = \frac{\mathbf{4075779.9}}{\mathbf{7.35}} = \mathbf{554301.6}\ \text{цн}$$

Эндээс малд идэгдэх бодит ургац **554301.6 цн** болж байна.

Бэлчээрийн багтаамжийг малд идэгдэх бодит ургацыг нэг хонин толгойн өдөрт идэх ургацтай харьцуулж тооцно. Үүнд:

$$\text{Бэлчээрийн багтаамж} = \frac{\text{Малд идэгдэх бодит ургац}}{\mathbf{1}\ \text{хон. тол өдөрт идэх ургац}} = \frac{\mathbf{554301.6}}{\mathbf{1.1}} = \mathbf{503910.6}\ \text{хон. тол}$$

3.2.2. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох. (Хонин сүрэг)

Хонин сүрэг нь Төв Азийн цаг уурын нөхцөлд бэлчээрээр маллахад зохицолдсон, биологи аж ахуйн өвөрмөц онцлогтой, ялангуяа уулархаг нутгийн бэлчээр чадамгай ашигладаг, хөнгөн, хүнсний үйлдвэрийн чухал түүхий эд бүтээдэг аж ахуй юм.

Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$\text{Мт} = \frac{\left[\frac{\text{АЖт}}{100} + (\text{АЖд} - \text{АЖт})\right] \text{НГт}}{100}$$

- **Мт** – Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ
- **АЖд** – дараах насны малын амьдын жин
- **АЖт** – тухайн насны малын амьдын жин
- **НГ** – тооцож буй малын нядалгааны гарц

Хүснэгт 5. Нядалгааны гарц тооцох норм

№	Малын төрөл	Нядалгааны гарц хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 6. Монгол хонины махны гарц тооцох норм

№	Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузны жин /кг/	Махны гарц /хувь/
1	12 сартай	28.9	10.2	42.5
2	1.5 настай	43.78	21.1	48.1
3	2.5 настай	51.0	26.9	52.7
4	3.5 настай	58.3	32.2	55.3
5	4.5 настай	60.5	33.5	55.3
6	5.5 настай	70.9	38.8	54.6

Хүснэгт 7. Хонин сургийн зохистой харьцаа (2016 оны малын тоо)

№	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	32.5	**13938**
3	3.5	16.1	**6922**
5	Хээлтэгч	51.4	**22037**
Бүгд		**100**	**42897**

Хүснэгт 8. Хонины махны ашиг шимийг бий болгох боломж

Нас, хүйс	Амьдын жин	Зун-намрын улиралд нэмэгдэх /нэг хонин толгойд/				Малын тоо	**Бүгд нэмэгдэх**
		Өвөл-хавар алдсан жин /кг/	Нас дэвших хүртэлх нэмэгдэх жин /кг/	Бүгд нэмэгдэх	Бүгд нэмэгдэл нядалгааны гарцаар		
1.5	43.8	13.1	7.2	20.3	9.7	13938	**135198.6**
3.5	58.3	17.5	2.2	19.7	9.5	6922	**65759**
Хээлтэгч	57	17.1	14	31.1	14.9	22037	**328351.3**
Бүгд	-	-	-	-	-	**42897**	**529308.9**

Дээрх хүснэгтээр тооцсон хонины махыг хонин толгойд шилжүүлбэл дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$Тх = \frac{АШмах + (АШмах * НГх)}{АЖэ/х}$$

- Тх – хонины тоо,
- АШмах – махан ашиг,
- НГх – нядалгааны гарцыг өсгөх хэмжээ (46/100=0.46)
- АЖэ/х – хонины амьдын жин /дунджаар/

$$Тх = \frac{\mathbf{3529308.9} + (\mathbf{3529308.9} * \mathbf{0.46})}{\mathbf{52.2}} = \mathbf{14804.4}\ \text{хон.тол}$$

Хүснэгт 9. Хонины сүү бий болгох чадавх

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Нийт авах сүү /л/
Эм хонь	22037	30	661110

Хүснэгт 10. Хонины ноос бий болгох чадавх

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноос /кг/	Нийт авах ноос /кг/
1	1.5	13938	1.3	18119.4
2	3.5	6922	2	13844
3	Хээлтэгч	22037	1.7	37462.9
Бүгд		**42897**	**-**	**69426.3**

Арьс, нэхий, дайвар бүтээгдэхүүн (толгой, цувдай, өлөн) бий болгох чадавх нь дээрх хүснэгтэд тооцсон хонин толгой **42897** тэнцүү тооны байна.

Хүснэгт 11. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх

Мах			Сүү			Ноос			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			**Бүгд дүн /төгрөг/**
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	
529308.9	5000	**2646544500**	661110	1500	**991665000**	69426.3	1500	**104139450**	42897	500	**21448500**	42897	2500	**107242500**	**3871039950**

Дээрх хүснэгтээс харахад Сэлэнгэ сумын хонин сүргийн хувьд **242540.6** га бэлчээрийн газрын бүтээгч чадавх **3871039950** төгрөг болж байна.

Эндээс хонин сүргийн хувьд 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$\text{БЧга} = \frac{\text{БЧ}}{\boldsymbol{S}} = \frac{\mathbf{3871039950}\ \text{төг}}{\mathbf{242540.6}\ \text{га}} = \mathbf{15960.4}\ \text{төгрөг}$$

3.2.3. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох. (Ямаан сүрэг)

Ямаан сүрэг нь манай орны цаг уурын нөхцөлд бэлчээрээр маллахад зохицолдсон, говь, цөлөрхөг хээр, уулархаг нутгийн бэлчээрийг чадамгай ашигладаг.

Монгол ямааны үндсэн ашиг шим нь сүү, мах, ноолуур, хялгас юм. Ямааны мах уураг их, тослог багатай. Ямааны махаар борц хийж хавар хэрэглэх, боодог хорхог хийдэг уламжлалтай. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$\text{Мт} = \frac{\left[\frac{\text{АЖт}}{\mathbf{100}} + (\text{АЖд} - \text{АЖт})\right] \text{НГт}}{\mathbf{100}}$$

- **Мт** – Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ
- **АЖд** – дараах насны малын амьдын жин
- **АЖт** – тухайн насны малын амьдын жин
- **НГ** – тооцож буй малын нядалгааны гарц

Хүснэгт 12. Нядалгааны гарц тооцох норм

№	Малын төрөл	Нядалгааны гарц хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 13. Ямааны махны гарц, жилийн өсөлт

№	Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузны жин /кг/	Нядалгааны гарц /хувь/	Мт-Махны жилийн өсөлт
1	12 сартай	28.9	10.2	42.5	1.7
2	1.5 настай	43.78	21.1	48.1	2.5
3	2.5 настай	51.0	26.9	52.7	6.5
4	3.5 настай	58.3	32.2	55.3	7.5
5	4.5 настай	60.5	33.5	55.3	11.4
6	5.5 настай	70.9	38.8	54.6	-

Хүснэгт 14. Ямаан сүргийн зохистой харьцаа (2016 оны малын тоо)

№	**Нас**	**Сүрэгт эзлэх хувь**	**Бүгд**
1	1.5	32.2	9217
3	3.5	18.7	5345
5	Хээлтэгч	49.1	14064
Бүгд		**100**	**28626**

Ямааны мах булчиндаа гадар өөх багатай, өөхөн сүүлгүй, харин дотор өөхний хуримтлал ихтэй, ямааны мах өөхний нядалгааны гарц 40-45 хувь байдаг. Ямааны өлөн гэдэс хиамны үйлдвэрийн чухал түүхий эд болох ба эврээр нь жижиг сам, цаасны хутга зэрэг эдлэл, туурайгаар нь цавуу хийдэг. Ямааны ясаар янз бүрийн ясан эдлэл хийж болохоос гадна нунтаглаж малын тэжээлийн хольц, газар тариалангийн сайн бордоо бэлтгэдэг.

Ямааны маханд нийтдээ 15 нэрийн амин хүчил байдаг. Борог маханд агуулагдах үл орлогдох амин хүчлийн хэмжээ өөхтэй махнаас харьцангуй их тодорхойлогдсон байна. Ямааны мах олон нэрийн хүчлээр баялаг, ханаагүй тосны хүчлийн агууламж өгдөг (45.7-49.1 хувь) төдийгүй уургийн үл орлогдох амин хүчил (44.0-39.0хувь) ихтэй чанартай мах хэмээн тодорхойлжээ (Л.Чой-Иш, 2005).

Монгол ямаа бэлчээрээр таргалах чадвар сайтай бөгөөд намар бүдүүн ухна 55-58, эм ямаа 37-41, шүдлэн ухна 35-38, охин шүдлэн 29-31 кг жин дардаг. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

Хүснэгт 15. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломж

Нас, хүйс	Амьдын жин	Гулуузны жин	Нядалгаа		Махны жилийн өсөлт /кг/	Малын тоо	Бүгд нэмэгдэх махны /кг/
			Жин	Хувь			
1.5	28.9	13.4	18.3	47.6	2.5	9217	23042.5
3.5	34.0	19.1	24.7	49.5	7.5	5345	40087.5
Хээлтэгч	48.9	24.7	16.0	50.4	6.5	14064	91416
Бүгд	-	-	-	-	-	**28626**	**154546**

Дээрх хүснэгтээр тооцсон ямааны махыг хонин толгойд шилжүүлбэл дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$Тх = \frac{АШмах + (АШмах * НГх)}{АЖэ/х}$$

- Тх – хонины тоо,
- АШмах – махан ашиг,
- НГх – нядалгааны гарцыг өсгөх хэмжээ (46/100=0.46)
- АЖэ/х – хонины амьдын жин /дунджаар/

$$Тх = \frac{\mathbf{154546 + (154546 * 0.46)}}{\mathbf{52.2}} = \mathbf{4322.6}\ хон.тол$$

Ямааны сүү нь тос бага, уураг их агуулсан, хялбар шингэх онцлогтой. Ямааны сүү харьцангуй тос багатай тул хүний биед амархан шингэдэг.

Ямаа саалийн хугацаандаа нэг ямаа дунджаар 60-70 литр сүү саалгадаг нь ноолуураасаа илүү орлого оруулах боломжтой. Саалийн хугацаа нь 7 сар буюу 6-р сарын 1-ээс 8-р дугаар сарын 15-ыг хүртэл ямааны сүүг ашигладаг. Сүүгээр нь бяслаг ба олон төрлийн цагаан идээ хийнэ. Цагаан болон хар ямааны сүүг эмчилгээний зориулалтаар болон эмийн бэлдмэл хийхэд ашигладаг. Ямааны сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно /Хүснэгт 16/.

Хүснэгт 16. Ямааны сүү бий болгох чадавх

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Нийт авах сүү /л/
Эм ямаа	14064	25	351600

Ямаан сүргийн тархалт дэлхийн өндөр уудам нутгийг хамрах учир тухайн улс орны цаг агаарын эрс халуун эсвэл бүр сэрүүн байдлаас хамаарч ямаа элгэн халцгай эсвэл хэт ноосорхог, зарим нь ноолууртай байдаг. Нэг ямаанаас дунджаар 250 грамм ноолуур гардаг. Нэг грамм цэвэр ноолууpаар 9-10 метр утас ээрдэг. Монгол улс нь дэлхийн нийт

ноолуурын 35-40хувь гаруй хувийг бэлтгэдэг. Монгол ямааны ноолуурын ширхэгийн голч 13.0-16.5 мкм, дундаж урт 38-45 мм бөгөөд монгол орны эрс тэс цаг ууртай холбогдон дулаан хадгалах чанарааараа бусад орны ямааны ноолуураас давуу талтай. Ямааны ноолууран бүтээгдэхүүн нь хөнгөн, уян зөөлөн, дулаан хадгалах болон хэлбэрээ хадгалах чадвар онцгой сайн, тансаг бүтээгдэхүүн бөгөөд зах зээлд байнгын эрэлт хэрэгцээтэй байдаг. Мөн манай оронд “Говь” үйлдвэр байгуулагдсанаар ноолууран бүтээгдэхүүний нэр төрөл, нэмэгдэж эхэлсэн бөгөөд сүүлийн жилүүдэд энэ чиглэлийн олон үйлдвэрүүд бий болж бүтээгдэхүүний тоо хэмжээ өсч, ноолуурын эрэлт хэрэгцээ ихэссэн. Энэ нь ноолуурын үнэ өсөхөд эерэг нөлөөлсөн. Үүний улмаас сүүлийн 17 жилд ямааны тоо 3 дахин өсөж малчдын орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд ихээхэн нэмэр болж байна.

Ухна 250-350 гр, эм ямаа 240-270 гр, борлон ухна 200-240 гр, охин борлон 200-230 гр, эр ямаа 240-380 гр ноолуур өгдөг. Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно /Хүснэгт 17/.

Хүснэгт 17. Ямааны ноолуур бий болгох чадавх

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноолуур /кг/	Нийт авах ноолуур /кг/
1	1.5	9217	0.19	1751.2
2	3.5	5345	0.3	1603.5
3	Хээлтэгч	14064	0.35	4922.4
Бүгд		**28626**	**-**	**8277.1**

Арьс, дайвар бүтээгдэхүүн (толгой, цувдай, өлөн) бий болгох чадавх нь дээрх хүснэгтэд тооцсон ямаан сүргийн тоо толгой 28626 тэнцүү тооны байна /Хүснэгт 18/.

Хүснэгт 18. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх

Мах			Сүү			Ноолуур			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			**Бүгд дүн /төгрөг/**
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	
154546	4000	618184000	351600	1200	421920000	8277.1	55000	455240500	28626	500	14313000	28626	2500	71565000	**1581225000**

Дээрх хүснэгтээс харахад Сэлэнгэ сумын ямаан сүргийн хувьд 242540.6 га бэлчээрийн газрын бүтээгч чадавх 1581222500 төгрөг болж байна.

Эндээс хонин сүргийн хувьд 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$\text{БЧга} = \frac{\text{БЧ}}{\boldsymbol{S}} = \frac{\mathbf{1581222500}\ \text{төг}}{\mathbf{242540.6}\ \text{га}} = \mathbf{6519,4}\ \text{төгрөг}$$

3.2.4. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох. (Үхэр сүрэг)

Сэлэнгэ суманд “Сэлэнгэ” үүлдрийн үхрийг өсгөн үржүүлж байна. Казакстан улс, Оросын холбооны улсын Оренбург, Волгаград мужид 1930-аад оноос эхлэн Казак болон нутгийн үхрийг махны чиглэлийн герефорд үхрээр эрлийзжүүлээд 2-3 дахь үеийг “өөр дотор” нь сонгон үржүүлэх аргаар “Казакын цагаан толгойт” үүлдрийн үхрийг буй болгожээ. Казакын цагаан толгойт үүлдрээр ойт-хээрийн бүсийн тухайлбал Булган аймгийн Сэлэнгэ сум, Сэлэнгэ аймгийн Орхон-туул сумын нутаг дахь монгол үхрийг 2-3 дахь үе хүртэл эрлийзжүүлж тохиромжтой хэвшлийн үхрийг цаашид “өөр дотор” нь шилэн сонгож үржүүлсээр 1980-аад оны дунд үе гэхэд махны чиглэлийн “Сэлэнгэ” үүлдрийн үхрийг буй болгосон. Энэ ажлыг Төрийн шагналт, мал зүйч Р.Жавзмаа удирдсан юм.

“Сэлэнгэ” үүлдрийн үхэр нь Сэлэнгэ, Булган аймаг, Төв аймгийн хойгуурх сумуудын нутагт тархсан. Энэ үүлдрийн үхрийн тугал 25-30 кг жинтэй төрөх бөгөөд эхлээр бойжуулаад эхээс ялгах үед эр нь 265-330 кг, охин нь 240-280 кг жинтэй байна. Сэлэнгэ үүлдрийн нас гүйцсэн бух 550-650 кг, үнээ 380-450 кг жинтэй. Сэлэнгэ үүлдэр болон Казахын цагаан толгойт монголын эрлийз үнээ дунджаар 1200-1500 кг сүүн ашиг шимтэй.

Үхрийн махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$\text{Мт} = \frac{\left[\frac{\text{АЖт}}{\mathbf{100}} + (\text{АЖд} - \text{АЖт})\right] \text{НГт}}{\mathbf{100}}$$

- **Мт** – Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ
- **АЖд** – дараах насны малын амьдын жин
- **АЖт** – тухайн насны малын амьдын жин

- **НГ** – тооцож буй малын нядалгааны гарц

Хүснэгт 19. Нядалгааны гарц тооцох норм

№	Малын төрөл	Нядалгааны гарц хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 20. Үхрийн махны гарцны норм

№	Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузны жин /кг/	Махны гарц /хувь/	Мт-Махны жилийн өсөлт
1	1.5 настай	359	215.4	60.0	8.8
2	2.5 настай	370	222	60.0	32.2
3	3.5 настай	380-420	228-252	60.0	20.5
4	4.5 настай	450	270	64.2	35.0
5	5.5 настай	550-650	330-390	60.0	-

Хүснэгт 21. Үхэр сургийн зохистой харьцаа (2016 оны малын тоо)

№	**Нас**	**Сүрэгт эзлэх хувь**	**Бүгд**
1	1.5	28.5	5124
3	3.5	28.3	5096
5	Хээлтэгч	43.2	7772
Бүгд		**100**	**17992**

Хүснэгт 22. Үхрийн махны ашиг шимийг бий болгох боломж

Нас, хүйс	**Амьдын жин**	**Гулуузны жин**	**Нядалгаа**		**Махны жилийн өсөлт /кг/**	**Малын тоо**	**Бүгд нэмэгдэх махны /кг/**
			Жин	**Хувь**			
1.5	359	215.4	129.4	40	8.8	5124	45091.2
3.5	420	252	151.2	40	20.5	5096	104468
Хээлтэгч	450	270	173.3	40	35.0	7772	270020
Бүгд	-	-	-	-	-	**17992**	**421579.2**

Дээрх хүснэгтээр тооцсон үхрийн махыг хонин толгойд шилжүүлбэл дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$Тх = \frac{АШмах + (АШмах * НГх)}{АЖэ/х}$$

- Тх – хонины тоо,
- АШмах – махан ашиг,
- НГх – нядалгааны гарцыг өсгөх хэмжээ (46/100=0.46),

- АЖэ/х – хонины амьдын жин /дунджаар/

$$\text{Тх} = \frac{\mathbf{421579.2} + (\mathbf{421579.2} * \mathbf{0.46})}{\mathbf{52.2}} = \mathbf{11791.3}\ \text{хон.тол}$$

Хүснэгт 23. Үхрийн сүү бий болгох чадавх

Хүйс	**Тоо, толгой**	**Нэгжээс авах сүү /л/**	**Нийт авах сүү /л/**
Үнээ	7772	1800	13989600

Арьс, дайвар бүтээгдэхүүн (цувдай, өлөн) бий болгох чадавх нь дээрх хүснэгтэд тооцсон үхрийн тоо толгой 17992 тэнцүү тооны байна.

Хүснэгт 24. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх

Мах			Сүү			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			**Бүгд дүн /төгрөг/**
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	**Бүгд**	
421579.2	6500	2740264800	13989600	1500	20984400000	17992	12000	215904000	17992	3000	53976000	**23994544800**

Дээрх хүснэгтээс харахад Сэлэнгэ сумын хонин сүргийн хувьд 242540.6 га бэлчээрийн газрын бүтээгч чадавх 23994544800 төгрөг болж байна.

Эндээс хонин сүргийн хувьд 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$\text{БЧга} = \frac{\text{БЧ}}{\boldsymbol{S}} = \frac{\mathbf{23994544800}\ \text{төг}}{\mathbf{242540.6}\ \text{га}} = \mathbf{98930.0}\ \text{төгрөг}$$

ДӨРӨВ. СУМЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН ТОХИРОМЖТОЙ БОЛОН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

4.1. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ

ГХГЗЗГ-ын даргын 2015 оны 09-р сарын 09-ний өдрийн А/200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүй”-н дагуу Орхон аймгийн Жаргалант сумын бэлчээр, тариалан, хот суурин, ой, зам, шугам сүлжээ болон аялал жуулчлалын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн.

4.1.1. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн бэлчээрийн ургамлын анги, бүлэг төрөл, идэмж, байгалийн бүс бүслүүр, гадаргын нөхцөл, усан хангамж, бэлчээрийн хэв шинж зэрэг үзүүлэлтэд үндэслэн үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг бэлчээрийн ургамлын 250 анги, бүлэг төрлөөр 7 үндсэн үзүүлэлтэд үндэслэн гүйцэтгэнэ /График 1/.

График 1. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем

Хүснэгт 25. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /өвөл-хавар/

№	Өвөл-хавар	Талбай /га/				
		Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
1	Бусад газар ашиглалт	436062.7	435999.0	436004.0	435924.4	436010.4
2	Нэн тохиромжгүй	9012.7	10298.2	11781.0	-	8845.7
3	Тохиромжгүй	5125.0	2139.3	28441.0	10287.9	1411.6
4	Хязгаарлагдмал тохиромжтой	17005.0	27637.6	8533.6	2624.6	16591.8
5	Тохиромжтой	17554.2	8685.5	-	35922.7	21900.1
Нийт		**484759.6**	**484759.6**	**484759.6**	**484759.6**	**484759.6**

График 2. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /өвөл-хавар/



	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Нэн тохиромжгүй	1.9	2.1	2.4		1.8
Тохиромжгүй	1.1	0.4	5.9	2.1	0.3
Хязгаарлагдмал тохиромжтой	3.5	5.7	1.8	0.5	3.4
Тохиромжтой	3.6	1.8		7.4	4.5

1. Өвөл-хаврын улиралд **адуунд** тохиромжтой бэлчээр /Зураг 2/. Үүнд:
   - **Тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 3.6 хувь буюу 17.6 мянган га талбай нь өвөл-хаврын улиралд адуунд тохиромжтой бэлчээр байна. Сэлэнгэ мөрний хоёр эргийн дагуух Цагаан тохой, Ихтийн адгийн тал, Халзан морьтын дэнж, Тариахтай багийн Харлагийн гол, Нарангийн голуудын хоёр эргийн тэгш тал газрууд, Тарихатай голын хөндийгөөр, Харцайн гол, Их өтөг, Цагаан толгой зэрэг уулын ам, хөндий, Сэлэнгэбүрэн багийн Санц толгой, Овоот уул урд энгэр газрууд нь өвөл-хаврын улиралд адуунд тохиромжтой бэлчээрт багтаж байна.
   - **Хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 3.5 хувь буюу 17.0 мянган га талбай нь өвөл-хаврын улиралд адуунд хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр байна. Далайн түвшнөөс дээш 800-100 метрийн өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд өвөл-хаврын улиралд адуунд хязгаарлагадмал тохиромжтой бэлчээрт багтаж байна. Ийм газрууд нь Шар чулуу

уулын урд энгэр, өндөр толгойн баруун хажуу, Нарст толгойн урд энгэр, эрээн мод толгойн урд энгэр, Шаврын эрээн нурууны урд энгэр, Ноён, Галсан, Нарс, Улаан зэрэг толгой, Бухын голын хоёр эргийн уулсын ам, хөндийнүүд нь өвөл-хаврын улиралд адуунд хязгаарлагдмал тохиромжтой бэлчээрт багтана.

- **Тохиромжгүй болон нэн тохиромжгүй бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 1.1 хувь буюу 5.1 мянган га талбай нь тохиромжгүй, 1.9 хувь буюу 9.0 мянган га талбай нь нэн тохиромжгүй бэлчээр байна. Далайн түвшнөөс дээш 1000 метрээс дээш өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд өвөл-хаврын улиралд адуунд тохиромжгүй буюу нэн тохиромжгүй бэлчээрт багтаж байна.

2. Өвөл-хаврын улиралд **хонинд** тохиромжтой бэлчээр /Зураг 3/. Үүнд:
   - **Тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 1.8 хувь буюу 8.9 мянган га талбай нь өвөл-хаврын улиралд хонинд тохиромжтой бэлчээр байна. Сэлэнгэ мөрний хоёр эргийн дагуух Цагаан тохой, Ихтийн адгийн тал, Халзан морьтын дэнж зэрэг далайн түвшнөөс дээш 800 мерт хүртэл өндөртэй тэгш тал газрууд нь өвөл-хаврын улиралд хонинд тохиромжтой бэлчээрт багтаж байна.
   - **Хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 5.7 хувь буюу 27.6 мянган га талбай нь өвөл-хаврын улиралд хонинд хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр байна. Тариахтай багийн Өрмөгтийн нуга, Донжин, Шар чулуу, Өндөр толгой, Өндөр Дэлгэр уул, Хадан хошуу толгойн урд энгэрээр, Тариахтай голын хоёр эрэг, Эрээн Мод толгойн урд энгэр, Сэлэнэгбүрэн багийн Таван толгой, Галсан толгой, Ноён толгой, Сант толгой, Овоот зэрэг уулсын урд энгэр, Атар багт Сэлэнгэ мөрний хойд эргийн тэгш, талархаг газар, Хүүхэд Овоот толгой, Хорхойтын хөндий, Таримал болон Ингэт багийн нутгаар Бухын гол, Ингэтийн голын хоёр талаарх уулсын ам хөндий газрууд багтана.
   - **Тохиромжгүй болон нэн тохиромжгүй бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 0.4 хувь буюу 2.1 мянган га талбай нь тохиромжгүй, 2.1 хувь буюу 10.1 мянган га талбай нь нэн тохиромжгүй бэлчээр байна. Далайн түвшнөөс дээш 1000 метрээс дээш өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд өвөл-хаврын улиралд адуунд тохиромжгүй буюу нэн тохиромжгүй бэлчээрт багтана.

3. Өвөл-хаврын улиралд **үхэрт** тохиромжтой бэлчээр /Зураг 5/. Үүнд:
   - **Тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 7.4 хувь буюу 34.0 мянган га талбай нь өвөл-хаврын улиралд хонинд тохиромжтой бэлчээр байна. Тариахтай багийн Өрмөгтийн нуга, Донжин, Шар чулуу, Өндөр толгой, Өндөр Дэлгэр уул,

Хадан хошуу толгойн урд энгэрээр, Тариахтай голын хоёр эрэг, Эрээн Мод толгойн урд энгэр, Сэлэнэгбүрэн багийн Таван толгой, Галсан толгой, Ноён толгой, Сант толгой, Овоот зэрэг уулсын урд энгэр, Атар багт Сэлэнгэ мөрний хойд эргийн тэгш, талархаг газар, Хүүхэд Овоот толгой, Хорхойтын хөндий, Долоон даваа, хар модотын уул, Баянцагаан уул, Таримал багт Бухйын голын хөндий, Зүүн бухын нурууны арцат, Төгөлдөр, Данжинбаатар, Шарын зэрэг амууд, Ингэт багийн нутгаар Бухын гол, Ингэтийн голын хоёр талаарх уулсын ам хөндий газрууд багтана.

4. Өвөл-хаврын улиралд **ямаанд** тохиромжтой бэлчээр /Зураг 6/. Үүнд:

- **Тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 4.5 хувь буюу 21.9 мянган га талбай нь өвөл-хаврын улиралд ямаанд тохиромжтой бэлчээр байна. Сэлэнгэ мөрний хоёр эргийн дагуух Цагаан тохой, Ихтийн адгийн тал, Халзан морьтын дэнж, Тариахтай багийн Харлагийн гол, Нарангийн голуудын хоёр эргийн тэгш тал газрууд, Тарихатай голын хөндийгөөр, Харцайн гол, Их өтөг, Цагаан толгой зэрэг уулын ам, хөндий, Сэлэнгэбүрэн багийн Санц толгой, Овоот уул урд энгэр газрууд багтаж байна.
- **Хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 3.4 хувь буюу 16.6 мянган га талбай нь өвөл-хаврын улиралд ямаанд хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр байна. Далайн түвшнөөс дээш 800-100 метрийн өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд өвөл-хаврын улиралд адуунд хязгаарлагадмал тохиромжтой бэлчээрт багтаж байна. Ийм газрууд нь Шар чулуу уулын урд энгэр, өндөр толгойн баруун хажуу, Нарст толгойн урд энгэр, эрээн мод толгойн урд энгэр, Шаврын эрээн нурууны урд энгэр, Ноён, Галсан, Нарс, Улаан зэрэг толгой, Бухын голын хоёр эргийн уулсын ам, хөндийнүүд нь өвөл-хаврын улиралд ямаанд хязгаарлагдмал тохиромжтой бэлчээрт багтана.
- **Тохиромжгүй болон нэн тохиромжгүй бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувь буюу 1.4 мянган га талбай нь тохиромжгүй, 1.8 хувь буюу 8.8 мянган га талбай нь нэн тохиромжгүй бэлчээр байна. Далайн түвшнөөс дээш 1000 метрээс дээш өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд өвөл-хаврын улиралд адуунд тохиромжгүй буюу нэн тохиромжгүй бэлчээрт багтаж байна.



Таниур	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
	Тохиромжтой	17554.2	3.6
	Бусад	436062.7	90.0
	Тохиромжгүй	5125.0	1.1
	Хязгаарлагдмал тохиромжтой	17005.0	3.5
	Цэн тохиромжгүй	9012.7	1.9
Нийт талбай		484759.6	100.0

*Зураг 2. Өвөл-хаврын улиралд **адуунд** тохиромжтой бэлчээр*



Зураг 3. Өвөл-хаврын улиралд хонинд тохиромжтой бэлчээр



Зураг 4. Өвөл-хаврын улиралд тэмээнд тохиромжтой бэлчээр



Зураг 5. Өвөл-хаврын улиралд үхэрт тохиромжтой бэлчээр



Зураг 6. Өвөл-хаврын улиралд ямаанд тохиромжтой бэлчээр

Хүснэгт 26. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /зун-намар/

№	Зун-намар	Талбай /га/				
		Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
1	Бусад газар ашиглалт	435914.7	436010.4	436066.5	435924.4	436010.4
2	Тохиромжгүй	3139.8	1411.6	7910.1	10287.9	1411.6
3	Нэн тохиромжгүй	-	8845.7	9116.2	-	8845.7
4	Хязгаарлагдмал тохиромжтой	35420.3	16591.8	19065.7	2624.6	16591.8
5	Тохиромжтой	7558.4	21900.1	12601.1	35922.7	21900.1
6	Нэн тохиромжтой	2726.5	-	-	-	-
Нийт		**484759.6**	**484759.6**	**484759.6**	**484759.6**	**484759.6**

График 3. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /зун-намар/



	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Тохиромжгүй	0.6	0.3	1.6	2.1	0.3
Нэн тохиромжгүй		1.8	1.9	0.0	1.8
Хязгаарлагдмал тохиромжтой	7.3	3.4	3.9	0.5	3.4
Тохиромжтой	1.6	4.5	2.6	7.4	4.5
Нэн тохиромжтой	0.6				

1. Зун-намрын улиралд **адуунд** тохиромжтой бэлчээр /Зураг 7/. Үүнд:
   - **Нэн тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 0.6 хувь буюу 3.1 мянган га талбай нь зун-намрын улиралд адуунд тохиромжтой бэлчээр байна. Энэ бэлчээр нь Тариахтай багийн Нарст толгой, Эрээн модот толгойн урд энгэрээр, Яргайтын ам, өндөр Дэлгэр уул, Өндөр толгой энгэр болон хажуугаар, өрмөгт уулын зүүн хажуугаар тус тус байна.
   - **Тохиромжтой болон хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 1.6 хувь буюу 7.6 мянган га талбай нь тохиромжтой, 7.3 хувь буюу 35.4 мянган га талбай нь хязгаарлагдмал тохиромжтой бэлчээрт багтаж байна. Тариахтай багийн Өрмөгтийн нуга, Донжин, Шар чулуу, Өндөр толгой, Өндөр Дэлгэр уул, Хадан хошуу толгойн урд энгэрээр, Тариахтай голын хоёр эрэг, Эрээн Мод толгойн урд энгэр, Сэлэнгбүрэн багийн Таван толгой, Галсан толгой,

Ноён толгой, Сант толгой, Овоот зэрэг уулсын урд энгэр, Атар багт Сэлэнгэ мөрний хойд эргийн тэгш, талархаг газар, Хүүхэд Овоот толгой, Хорхойтын хөндий, Долоон даваа, хар модотын уул, Баянцагаан уул, Таримал багт Бухйын голын хөндий, Зүүн бухын нурууны арцат, Төгөлдөр, Данжинбаатар, Шарын зэрэг амууд, Ингэт багийн нутгаар Бухын гол, Ингэтийн голын хоёр талаарх уулсын ам хөндий газрууд багтана.

2. Зун-намрын улиралд **хонинд** тохиромжтой бэлчээр /Зураг 8/. Үүнд:
   - **Тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 4.5 хувь буюу 21.9 мянган га талбай нь зун-намрын улиралд хонинд тохиромжтой бэлчээр байна. Сэлэнгэ мөрний хоёр эргийн дагуух Цагаан тохой, Ихтийн адгийн тал, Халзан морьтын дэнж, Тариахтай багийн Харлагийн гол, Нарангийн голуудын хоёр эргийн тэгш тал газрууд, Тарихатай голын хөндийгөөр, Харцайн гол, Их өтөг, Цагаан толгой зэрэг уулын ам, хөндий, Сэлэнгэбүрэн багийн Санц толгой, Овоот уул урд энгэр газрууд нь багтаж байна.
   - **Хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 3.4 хувь буюу 16.6 мянган га талбай нь зун-намрын улиралд хонинд хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр байна. Тариахтай багийн Өрмөгтийн нуга, Донжин, Шар чулуу, Өндөр толгой, Өндөр Дэлгэр уул, Хадан хошуу толгойн урд энгэрээр, Тариахтай голын хоёр эрэг, Эрээн Мод толгойн урд энгэр, Сэлэнэгбүрэн багийн Таван толгой, Галсан толгой, Ноён толгой, Сант толгой, Овоот зэрэг уулсын урд энгэр, Атар багт Сэлэнгэ мөрний хойд эргийн тэгш, талархаг газар, Хүүхэд Овоот толгой, Хорхойтын хөндий, Таримал болон Ингэт багийн нутгаар Бухын гол, Ингэтийн голын хоёр талаарх уулсын ам хөндий газрууд багтана.
   - **Тохиромжгүй болон нэн тохиромжгүй бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувь буюу 1.4 мянган га талбай нь тохиромжгүй, 1.8 хувь буюу 8.8 мянган га талбай нь нэн тохиромжгүй бэлчээр байна. Далайн түвшнөөс дээш 1000 метрээс дээш өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд өвөл-хаврын улиралд адуунд тохиромжгүй буюу нэн тохиромжгүй бэлчээрт багтана.
3. Зун-намрын улиралд **үхэрт** тохиромжтой бэлчээр /Зураг 10/. Үүнд:
   - **Тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 7.4 хувь буюу 35.9 мянган га талбай нь зун-намрын улиралд үхэрт тохиромжтой бэлчээр байна. Тариахтай багийн Өрмөгтийн нуга, Донжин, Шар чулуу, Өндөр толгой, Өндөр Дэлгэр уул, Хадан хошуу толгойн урд энгэрээр, Тариахтай голын хоёр эрэг, Эрээн Мод

толгойн урд энгэр, Сэлэнэгбүрэн багийн Таван толгой, Галсан толгой, Ноён толгой, Сант толгой, Овоот зэрэг уулсын урд энгэр, Атар багт Сэлэнгэ мөрний хойд эргийн тэгш, талархаг газар, Хүүхэд Овоот толгой, Хорхойтын хөндий, Долоон даваа, хар модотын уул, Баянцагаан уул, Таримал багт Бухйын голын хөндий, Зүүн бухын нурууны арцат, Төгөлдөр, Данжинбаатар, Шарын зэрэг амууд, Ингэт багийн нутгаар Бухын гол, Ингэтийн голын хоёр талаарх уулсын ам хөндий газрууд багтана.

4. Зун-намрын улиралд **ямаа** тохиромжтой бэлчээр /Зураг 11/. Үүнд:

- **Тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 4.5 хувь буюу 21.9 мянган га талбай нь зун-намрын улиралд ямаанд тохиромжтой бэлчээр байна. Сэлэнгэ мөрний хоёр эргийн дагуух Цагаан тохой, Ихтийн адгийн тал, Халзан морьтын дэнж, Тариахтай багийн Харлагийн гол, Нарангийн голуудын хоёр эргийн тэгш тал газрууд, Тарихатай голын хөндийгөөр, Харцайн гол, Их өтөг, Цагаан толгой зэрэг уулын ам, хөндий, Сэлэнгэбүрэн багийн Санц толгой, Овоот уул урд энгэр газрууд багтаж байна.
- **Хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 3.4 хувь буюу 16.6 мянган га талбай нь зун-намрын улиралд ямаанд хязгаарлагдмал тохиромжтой бэлчээр байна. Далайн түвшнөөс дээш 800-100 метрийн өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд өвөл-хаврын улиралд адуунд хязгаарлагадмал тохиромжтой бэлчээрт багтаж байна. Ийм газрууд нь Шар чулуу уулын урд энгэр, өндөр толгойн баруун хажуу, Нарст толгойн урд энгэр, эрээн мод толгойн урд энгэр, Шаврын эрээн нурууны урд энгэр, Ноён, Галсан, Нарс, Улаан зэрэг толгой, Бухын голын хоёр эргийн уулсын ам, хөндийнүүд нь өвөл-хаврын улиралд ямаанд хязгаарлагдмал тохиромжтой бэлчээрт багтана.
- **Тохиромжгүй болон нэн тохиромжгүй бэлчээр.** Нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувь буюу 1.4 мянган га талбай нь тохиромжгүй, 1.8 хувь буюу 8.8 мянган га талбай нь нэн тохиромжгүй бэлчээр байна. Далайн түвшнөөс дээш 1000 метрээс дээш өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд өвөл-хаврын улиралд адуунд тохиромжгүй буюу нэн тохиромжгүй бэлчээрт багтаж байна.



Таниур	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
	Тохиромжтой	7558.4	1.6
	Бусад	435914.7	89.9
	Тохиромжтуй	3139.8	0.6
	Хязгаарлагдмал тохиромжтой	35420.3	7.3
	Нэн тохиромжтой	2726.5	0.6
Нийт талбай		484759.6	100.0

Зураг 7. Зун-Намрын улиралд адуунд тохиромжтой бэлчээр



Таниур	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
	Тохиромжтой	21900.1	4.52
	Бусад	436010.4	89.94
	Тохиромжгүй	1411.6	0.29
	Хязгаарлагдмал тохиромжтой	16591.8	3.42
	Пэн тохиромжгүй	8845.7	1.82
Нийт талбай		484759.6	100.0

Зураг 8. Зүн-Намрын улиралд хонинд тохиромжтой бэлчээр



Зураг 9. Зун-Намрын улиралд тэмээнд тохиромжтой бэлчээр



Зураг 10. Зун-Намрын улиралд үхэрт тохиромжтой бэлчээр



Зураг 11. Зүн-Намрын улиралд ямаанд тохиромжтой бэлчээр

4.1.2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Тариалангийн газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.

Тариаланд тохиромжтой газрын иж бүрэн үнэлгээ өгөхдөө хүрээлэн буй орчныг нэгдсэн систем гэж үзэж, байгаль болон нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүдийг хослуулж 5 шатлалтай ангиллаар үнэлгээний хүчин зүйлсийн үзүүлэлт бүрд тохируулан тогтоосон онооны (баллын) аргаар үнэлгээг боловсруулна. Үүнд:

1. Геофизик хүчин зүйлийн үнэлгээ
    - Газрын гадаргын үнэлгээ;
    - Гидрологийн үнэлгээ;
    - Инженер-геологийн үнэлгээ;
    - Хөрсний үнэлгээ;
2. Уур амьсгалын үнэлгээ
    - Агаарын температур;
    - Хур тунадас;
    - Дулаан хангамжийн нөхцөл;
    - Чийг хангамжийн нөхцөл;
3. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ
    - Ой бүхий талбай;
    - Хот суурингийн газар;
    - Зам, шугам сүлжээний газар;
    - Тариалангийн талбай;
    - Уул уурхайн талбай;
    - Түүх соёлын дурсгалт газар;
    - Археологийн үнэт олдвор;
    - Гол, мөрөн;
    - Булаг, худаг уст цэг;
    - Манхан элс;

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд дараах 3 үндсэн, 29 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэсэн. /График 4/

График 4. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд



Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үндэслэн Сэлэнгэ сумын нийт нутаг дэвсгэрийн тариаланд тохиромжтой газрын талбайн хэмжээг тодорхойлоход 4.3 хувь буюу 21.0 мянган га талбай нэн тохиромжтой, 5.2 хувь буюу 25.0 мянган га талбай тохиромжтой, 0.3 хувь буюу 1.4 мянган га талбай дунд зэрэг тохиромжтой, 0.0001 хувь буюу 0.4 га талбай тохиромжгүй газар байна /Хүснэгт 27/.

Хүснэгт 27. Тариаланд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

№	Үнэлгээ	Талбай /га/	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	437256.2	90.2
2	Тохиромжгүй	0.4	0.0001
3	Дунд зэрэг тохиромжтой	1423.3	0.3
4	Тохиромжтой	25035.6	5.2
5	Нэн тохиромжтой	21044.0	4.3
Нийт талбай		**484759.6**	**100**

- **Нэн тохиромжтой.** Сэлэнгэ сумын тариаланд нэн тохиромжтой газруудад Сэлэнгэ мөрний хоёр эргийн дагуух газрууд Цагаан тохой, Ихтийн адгийн тал, Халзан морьтын дэнж, Тариахтай багийн Харлагийн гол, Нарангийн голуудын хоёр эргийн тэгш тал газрууд, Тарихатай голын хөндийгөөр, Харцайн гол, Их өтөг, Цагаан толгой зэрэг уулын ам, хөндий, Сэлэнгэбүрэн багийн Санц толгой, Овоот уул урд энгэр газрууд багтана.
- **Тохиромжтой.** Далайн түвшнөөс дээш 800-100 метрийн өндөрт өргөгдсөн уулын энгэр, ар, хажуу газрууд болох Шар чулуу уулын урд энгэр, өндөр толгойн баруун

хажуу, Нарст толгойн урд энгэр, эрээн мод толгойн урд энгэр, Шаврын эрээн нурууны урд энгэр, Ноён, Галсан, Нарс, Улаан зэрэг толгой, Бухын голын хоёр эргийн уулсын ам, хөндийнүүд багтана.



Зураг 12. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

4.1.3. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.

Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд нийт 3 үндсэн, 35 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ /График 5/.

График 5. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний үзүүлэлт



Дээрх 3 үндсэн болон 35 дэд үзүүлэлтийг үндэслэн шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээг гаргахад нийт нутаг дэвсгэрийн 8.4 хувь буюу 40.6 мянган га талбай тохиромжтой, 1.1 хувь буюу 5.3 мянган га талбай дунд зэрэг тохиромжтой, 0.1 хувь буюу 294.5 га талбай тохиромжгүй ангилалд орж байна /Хүснэгт 28/.

Хүснэгт 28. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбай

№	Үнэлгээ	Талбай /га/	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	438628.1	90.5
2	Тохиромжгүй	294.5	0.1
3	Дунд зэрэг тохиромжтой	5275.8	1.1
4	Тохиромжтой	40561.2	8.4
Нийт		**484759.6**	**100**

График 6. Шинээр байгуулах хот, суурин газарын тохиромжтой байдлын үнэлгээ



- **Тохиромжтой.** Тариахтай багийн Өрмөгтийн нуга, Донжин, Шар чулуу, Өндөр толгой, Өндөр Дэлгэр уул, Хадан хошуу толгойн урд энгэрээр, Тариахтай голын хоёр эрэг, Эрээн Мод толгойн урд энгэр, Сэлэнэгбүрэн багийн Таван толгой, Галсан толгой, Ноён толгой, Сант толгой, Овоот зэрэг уулсын урд энгэр, Атар багт Сэлэнгэ мөрний хойд эргийн тэгш, талархаг газар, Хүүхэд Овоот толгой, Хорхойтын хөндий, Долоон даваа, хар модотын уул, Баянцагаан уул, Таримал багт Бухйын голын хөндий, Зүүн бухын нурууны арцат, Төгөлдөр, Данжинбаатар, Шарын зэрэг амууд, Ингэт багийн нутгаар Бухын гол, Ингэтийн голын хоёр талаарх уулсын ам хөндий газрууд багтана.
- **Дунд зэрэг тохиромжтой.** Тариахтай багийн Өрмөгтийн нуга, Донжин уул, Өрмөгт уулын энгэр газрууд багтана.



Зураг 13. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ

4.1.4. Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Байгалийн нөөц рекреацийн нутаг дэвсгэр ашиглалтын урьдчилсан нөхцөлүүдийн нэг гол хүчин зүйл, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой юм.

Ландшафт-рекреацийн чадавхийн үнэлгээнд дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Ландшафтын үнэлгээ
   - Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээ
   - Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээ
   - Гадаргын ус- рашааны аялал-рекреацийн үнэлгээ
   - Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ
   - Ландшафтын гоо зүйн үнэлгээ
2. Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ
   - Байгаль-соёлын дурсгалт газар
   - Түүх- соёлын дурсгалт газар
3. Дэд бүтцийн үнэлгээ
   - Гатлага, зам (даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ)
   - Хот болон байнгын оршин суух газарт ойрхон эсэх
   - Тохижилтын түвшин
4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ
   - Тариалангийн талбай
   - Одоо байгаа хот суурин газар
   - Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
   - Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс

Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль, түүх, соёлын дурсгалт, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Байгалийн аялал- рекреацыг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ”-г боловсруулна. Байгалийн аялал-рекреацыг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээг 3 шатлалтай ангиллаар нийт 4 үндсэн, 27 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ /График 6/.

График 7. Ландшафтын үнэлгээний схем



Дээрх үзүүлэлтийг үндэслэн аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг гаргахад нийт нутаг дэвсгэрийн 8.5 хувь буюу 41.0 мянган га талбай тохиромжтой, 1.3 хувь буюу 6.3 мянган га талбай дунд зэрэг тохиромжтой, 0.3 хувь буюу 1.3 мянган га талбай тохиромжгүй ангилалд орж байна /Хүснэгт 29/.

Хүснэгт 29. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбай

№	Үнэлгээ	Талбай /га/	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	436107.7	90.0
2	Тохиромжгүй	1336.8	0.3
3	Дунд зэрэг тохиромжтой	6280.3	1.3
4	Тохиромжтой	41034.8	8.5
Нийт талбай		**484759.6**	**100**



Зураг 14. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

4.1.5. Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээ”-г боловсруулна.

Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээг хийхэд зураг 1-д тусгагдсан нийт 3 үндсэн, 6 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

График 8. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ



Хүснэгт 30. Авто болон төмөр зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглах газрын тохиромжтой газрын талбай

№	Үзүүлэлт	Авто болон төмөр замын зориулалтаар ашиглах тохиромжтой газрын хэмжээ		Шугам, сүлжээний зориулалтаар ашиглах тохиромжтой газрын хэмжээ	
		Талбай /га/	Хувь	Талбай /га/	Хувь
1	Нэн хүндрэлтэй	68848.5	14.2	68762.4	14.2
2	Хүндрэлтэй	338675.9	69.9	338853.8	69.9
3	Хэвийн	77235.2	15.9	77143.4	15.9
Нийт		**484759.6**	**100**	**484759.6**	**100**



Зураг 15. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ



Зураг 16. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

4.1.6. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Ой ургах тохиромжтой газрын үнэлгээг гадаргын төрх байдал, хөрсний физик-химийн шинж чанарын үзүүлэлт, газар ашиглалт зэрэг хүчин зүйлийн дотроос сонгон авч шалгуур үзүүлэлтийг боловсруулна. Үүнд:

1. Газрын гадаргын үнэлгээ
   - Гадаргын хэвгий
   - Зүг зовхис
   - Гадаргын өндөршил
2. Хөрсний физик-химийн хүчин зүйлийн үнэлгээ
   - Хөрсний хэв шинж
   - Хөрсний механик бүрэлдэхүүн
   - Ялзмагт үеийн зузаан
   - Хөрсний ус нэвчүүлэх чадвар
   - Хөрсний ялзмагийн агууламж
   - Хөрсний урвалын орчин
   - Кальцийн карбонат
   - Хөрсний цахилгаан дамжуулах чадвар
   - Хөрсний чийг
3. Газар ашиглалтын нөхцөлийн үнэлгээ
   - Хот суурины эдэлбэр газар
   - Тариалангийн газар
   - Ашиглаж буй уул уурхайн газар
   - Зам шугам, сүлжээний газар
   - Гол горхи, нуур

Тухайн орон нутаг, бүс нутгийн ой-ургамалжлын муж, хошуу, өндрийн бүслүүр ангилалд үндэслэн гадаргын нөхцөл, хөрсний шинж чанарыг илтгэх үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээг байгалийн 3 өөр муж, 9 хошуу, өндрийн бүслүүрээр ялгаатай 22 ойн хэв шинжид үндэслэн нийт 3 үндсэн, 11 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

График 9. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ



Ойн сангийн тохиромжтой газрын үнэлгээний үзүүлэлтээр тус сумын нийт нутаг дэвсгэрийн 3.0 хувь буюу 1.7 мянган га талбай нь ойн ургах тохиромжтой, 53.3 хувь буюу 30.2 мянган га талбай хязгаарлагдмал тохиромжтой газар гэж тус тус гарсан байна /Хүснэгт 31/

Хүснэгт 31. Ойн сангийн тохиромжтой газрын талбай

№	Үнэлгээ	Талбай /га/	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	436017.9	90.0
2	Тохиромжгүй	10364.7	2.1
3	Дунд зэрэг тохиромжтой	30120.8	6.2
4	Тохиромжтой	8256.1	1.7
Нийт		**484759.6**	**100**



Таниур	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
	Бусад газар ашиглалт	436017.9	89.9
	Тохиромжгүй	10364.6	2.1
	Дунд зэрэг тохиромжтой	30120.8	6.2
	Тохиромжтой	8256.1	1.7
Нийт талбай		484759.6	100

Зураг 17. Ойн сангийн зориулалтын газрын тохиромжтой байдлын үнэлгээ

4.1.7. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Газар нутгийн хадгалан хамгаалах нь оршин тогтнох эх үндэс, хүмүүсийн амьдралыг тэтгэгч ус, цэвэр агаар, эрүүл орчинг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй билээ. Түүнчлэн биологийн төрөл зүйлийн нөөцийг тогтвортой, эрүүл байлгах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад бидний амьдарч буй орчин нөлөөлдөг. Иймээс эдгээр шинж чанарыг авч үлдэхийн тулд хадгалан хамгаалах зайлшгүй шаардлагатай.

Хадгалан хамгаалах газрын үнэлгээ хийхдээ хамгаалах амьтан, ургамлын зүйлийг тодорхойлохоос эхэлдэг бөгөөд дараах аргыг хэрэглэдэг. Үүнд:

1. Амьдрах орчны хамгаалал болон газар нутгийг тусгай хамгаалалтад авах, байгаль орчны төлөвлөгөө боловсруулах
2. Уул уурхай болон эрчим хүчний хөгжил тэдгээрийн нөлөөг бууруулах
3. Биологийн судалгаа болон хяналт шинжилгээ
4. Экосистемийн үйлчилгээний үнэлгээний хүрээнд бэлчээр болон усны нөөцийг тогтоох зэрэг ашигладаг.

Амьтны тархацын зүйлийн тархацын загвар гаргахад дараах мэдээллийг ашиглана. Үүнд:

Амьдрах орчны тодорхойлолт-тухайн зүйлийн амьдрах орчны физик шинж чанар болон хүрээлэн буй орчны тодорхойлолт

1. Ажиглалт судалгааны мэдээ
2. Идэж тэжээл
3. Өндөршил
4. Гадаргын хэлбэр
5. Экосистемийн ангилал
6. Хур тунадас зэрэг болно



Зураг 18. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

4.2. Орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээ

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад нутгийн иргэдийн оролцоо хамгаас чухал. Төлөвлөгөө боловсруулахдаа иргэдийн оролцоог хангаж орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээг гаргах үүднээс малчин, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг судалгаанд хамруулсан болно.

Тухайн сумын газар ашиглалтын өнөөгийн нөхцөл байдалд нөлөөлж буй дотоод, гадаад хүчин зүйлийг үнэн зөв тодорхойлох, газрын хэрэгцээ болон газар ашиглалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж газар ашиглалтын онцлогийг тодруулах үүднээс зорилтод бүлгүүдийг хамарсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

4.2.1. Иргэн, хуулийн этгээд, малчдын хэрэгцээт байдлын үнэлгээ

Тус сумын 5 багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний загвар төслийг танилцуулж, холбогдох саналыг хэлэлцүүлсэн. Санал хэлэлцүүлгийг төлөвлөгөөндөө тусган багийн иргэдийн нийтийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрүүдийг /тэмдэглэл/ зурагт буулган боловсруулалт хийж сумын Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн санал бодлыг авч төлөвлөгөөг боловсруулсан.

Мөн тухайн сумын нийгэм-эдийн засаг, байгалийн нөөц, баялгийн ашиглалт, газар ашиглалттай холбоотой ярилцлага, хэлэлцүүлэг, санал асуулгын судалгаанд 5 багийн нийт иргэдээс түүвэрлэх байдлаар 119 хүнийг сонгон нутгийн иргэдийн хэрэгцээт байдлын үнэлгээг боловсруулсан.

Судалгаанд хамрагдсан иргэдийн төлөөлөл болон санал асуулгын хариултыг тоймлон дараах хүснэгтүүдэд үзүүлэв /Хүснэгт 32, 33/

Хүснэгт 32. Судалгаанд хамрагдсан иргэдийн төлөөлөл

Иргэн, хуулийн этгээд	Багийн нэр					Нийт судалгаанд хамрагдсан
	Таримал	Тариахтай	Сэлэнгэбүрэн	Атар	Ингэт	
Малчин өрх	10	20	17	17	13	**77**
Сумын төвийн өрх	11	-	-	-	15	**26**
Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч	2	4	3	3	2	**14**
ЗДТГ-ын албан хаагчид	1	-	-	-	1	**2**
Дүн	**24**	**24**	**20**	**20**	**31**	**119**

Хүснэгт 33. Санал, асуулгын хураангуй

№	Багийн нэр	Саналын төрөл	Хүний тоо	Эзлэх хувь
1	Таримал	Хадлангийн талбайг бүсчилж хариуцах эзэнтэй болгох	24	62.5
		Малын үүлдэр, угсааг сайжруулах, ЭМАА эрхлэх		20.8
		Мал эмнэлгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох		41.7
		Мэдээ, мэдээллийн сүлжээ муу, интернетийг хүртээмжтэй болгох		12.5
		Мах, ногоо хадгалах хүйтэн болон мөсөн зоорь барих		25.0
		Түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудад түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх		33.3
		Сэлэнгэ мөрнийг түшиглэн загасчлах спортоор жуулчдыг татах		25.0
		Машин техник зорчиход бэрх даваа, гүвээг засах, зарим гатлах боломжгүй гол, ус, намагтай газарт гүүр барих		20.8
2	Тариахтай	“Зэд Хантай Бүтээлийн нуруу” ДЦГ-ийн нийт хамгаалалтын газраас хасаж тус багийн бэлчээрийн газрын хэмжээг нэмэгдүүлэх	24	70.8
		Хадлан хаддаг газруудыг нэмэгдүүлэх		83.3
		Тоосго цохих, хайргаа ашиглан блок хавтан үйлдвэрлэж, хямд өртөгтэй барилгын материал зах зээлд		8.3
		Жимс жимсгэнэ, самар, эмийн ургамал элбэгтэй боломжоо ашиглан эмийн ургамлын үйлдвэр, хөгжүүлэх		8.3
3	Сэлэнгэбурэн	“Зэд Хантай Бүтээлийн нуруу” ДЦГ-ийн нийт хамгаалалтын газраас хасаж тус багийн бэлчээрийн газрын хэмжээг нэмэгдүүлэх	20	85.0
		Хадлан хаддаг газруудыг нэмэгдүүлэх		65.0
		Усалгаатай газар тариалан эрхлэх		50.0
4	Атар	“Зэд Хантай Бүтээлийн нуруу” ДЦГ-ийн нийт хамгаалалтын газраас хасаж тус багийн бэлчээрийн газрын хэмжээг нэмэгдүүлэх	20	85.0
		Хадлан хаддаг газруудыг нэмэгдүүлэх		65.0
		Усалгаатай газар тариалан эрхлэх		10.0
		Байгалийн тэнцвэрт зохистой харьцааг хадгалах замаар загас үржүүлэг, загасчлах спорт /өвөл, зун/ хөгжүүлэх		20.0
		Мал эмнэлгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох		40.0
5	Ингэт	Зөгий үржүүлгийн аж ахуйг хөгжүүлэх	31	6.5
		Хадлангийн талбайг бүсчилж хариуцах эзэнтэй болгох		32.3
		Малын үүлдэр, угсааг сайжруулах, ЭМАА эрхлэх		16.1
		Мэдээ, мэдээллийн сүлжээ муу, интернетийг хүртээмжтэй болгох		9.7
		Түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудад түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх		32.3
		Машин техник зорчиход бэрх даваа, гүвээг засах, зарим гатлах боломжгүй гол, ус, намагтай газарт гүүр барих		51.6

Орон нутгийн иргэд оролцож, тэдний санал тусгагдаж байж төлөвлөгөө хэрэгжих боломж хангагдана. Иймээс дээрх нийгэм-эдийн засаг, байгалийн нөөц, баялгийн ашиглалт, газар ашиглалттай холбоотой судалгааг үндэслэн SWOT шинжилгээ хийж, AHP (Analytic Hierarchy Process) буюу хүчин зүйлсийг хоёр хоёроор нь харьцуулж үнэлгээ өгөх аргаар хүчин зүйлсэд үнэлгээ өглөө. Олон нийтийн оролцоотой тодорхойлж, үнэлсэн SWOT шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв /Хүснэгт 35/.

Хүснэгт 34. SWOT шинжилгээний үр дүн

Хүчин зүйлс	**Дэд хүчин зүйлс**
Давуу тал	• Тус сумын төвийн эрчим хүчний системд холбогдсон, хөдөөгийн багууд өндөр хүчдэлд холбогдсон; • Байршлын хувьд Орхон, Дархан Улаанбаатар, ОХУ-тай харьцахад ойрхон, төмөр зам болон босоо тэнхлэгийн замд холбогдсон; • Цэвэр усаар хангамж маш сайн; • Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа тогтмолжсон, барилга байгууламж сайн. • Сургалтын орчин нөхцөл хангалттай; • Эмнэлэг хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эрхээ 4 жилээр авсан, барилга шинээр баригдсан, шинэ түргэн тусламжийн машинтай зайлшгүй шаардлагатай эм хэрэгслээр хангагдсан; • Эрүүл мэндийн сургалт явуулах сургалтын техник хэрэгсэл, чийрэгжүүлэлтийн эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан; • Багуудад цэцэрлэг, бага сургууль, бага эмчийн салбартай; • Газар тариалангийн үйлдвэрлэл сэргэж, эргэлтийн талбайг сайн ашиглаж, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бог будаа нь үндэсний тохирлын тэмдэгтэй болж зах зээлд байр суурьтай болсон; • Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхэртэй;
Сул тал	• Мэдээ, мэдээллийн сүлжээ муу, интернет хүртээмж бага; • Худалдаа үйлчилгээний бөөний төв болон цайны газар, зочид буудал байхгүй; • Суманд нэгдсэн бохир ус, цэвэр усны машин байхгүй; • Аялал жуулчлал муу хөгжсөн; • Иргэд байгаль орчноо хамгаалах зүй зохистой ашиглах хуулийн хүрээнд тавих дотоод хяналт сул; • Хөдөөгийн багууд сумын төвөөс алслагдмал, Сэлэнгэ мөрний хойно байдаг нь зам харилцааны дэд бүтэц хөгжөөгүй; • Эдийн засгийн гадагшаа урсгалтай; • Махны чиглэлийн үхэр үржүүлдэг боловч хүйтэн болон мөсөн зоорьгүй.
Боломж	• Байгалийн тэнцвэрт зохистой харьцааг хадгалах замаар загас үржүүлэг, загасчлах спорт /өвөл, зун/ хөгжүүлэх; • Тоосго цохих, хайргаа ашиглан блок хавтан үйлдвэрлэж, хямд өртөгтэй барилгын материал зах зээлд нийлүүлэх боломжтой. • Жимс жимсгэнэ, самар, эмийн ургамал элбэгтэй боломжоо ашиглан эмийн ургамлын үйлдвэр, цайны үйлдвэр зэрэг жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх боломжтой; • Халтар арвай, хөх арвай, цагаан арвай, хар будааг өргөн тариалуулж, хар талх болон зохицуулах үйлчилгээний хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой; • Иргэн бүр газартай болох идэвхи санаачлагыг дэмжиж төмс хүнсний ногоог боловсруулах төмс шарах, хатаах, пүнтүүз хийх, ногоо лаазалж, хөлдөөх зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой; • Усалгаатай талбайг нэмэгдүүлэх, усалгаатай тариалан эрхлэх боломжтой; • Хагас болон бүрэн механикжсан сүүний фермер хөгжүүлэх боломжтой; • Эрчимжсэн фермер байгуулахад хадлан тэжээл бэлтгэн МАА, газар тариалан, хослуулан хөгжүүлэх боломжтой; • Зөгийн аж ахуй эрхлэх боломжтой; • Байгалийн дагалдах баялгийг ашиглах, боловсруулах цех, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой;

Дээрх нутгийн удирдлага болон ард иргэдээс авсан санал асуулгын үр дүнг тус сумын “Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-нд тусган, ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээг тодорхойлж өгснөөр сумын тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой.

ТАВ. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөний чиг баримжаа нь “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”, “Сумын хөгжлийн цогц бодлого 2016-2021 он” зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулсан болно.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн чиглэл бүрээр тодорхой тусгалаа.

График 10. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний үндсэн чиг хандлага

“Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-г газрын болон байгалийн нөөц, нөхцөлд тулгуурлан дараах эрхзүйн баримт бичгийг үндэслэн боловсруулсан. Үүнд:

- Монгол Улсын “Газрын тухай” хууль. УБ. 2002 он
- Монгол Улсын “Авто замын тухай” хууль. УБ. 2017 он
- Монгол Улсын “Ойн тухай” хууль. УБ. 2012 он
- Монгол Улсын “Аялал жуулчлалын тухай” хууль. УБ. 2000 он
- Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хууль. УБ. 2001 он
- Монгол Улсын “Усны тухай” хууль. УБ. 2012 он
- “Аймаг, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар” УБ, 2008 он.
- “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он.
- ГЗБГЗЗГ-ын даргын 2017 оны А/278 тоот тушаал “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”
- ЗГ-ын 2001 оны 263-р тогтоол “Эрчим хүчний шугам, сүлжээг хамгаалах дүрэм”
- БОАЖЯ, ЭМЯамны сайд нарын 2009 оны 51/75 дугаар хамтарсан тушаал “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”
- ГХГЗЗГ-ын даргын А/22 тоот тушаал “Газар, байгалийн нөөц, эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар бүртгэн, баталгаажуулах түр журам” 2016 он.
- ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаал “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга зүй”



Зураг 19. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө

5.2. Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө

Сэлэнгэ сумын нутагт гадаргын ус болон зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсүүдийг дараах зорилгоор тогтоосон. Үүнд:

- Усны эх, ундарга, нөөцийг хомстох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх;
- Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, хүн, амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх;

Тус сумын нутагт гадаргын ус болон зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсүүдийг дараах хууль, дүрэм, журам, стандартыг баримталж тогтоосон /Хүснэгт 35/.

Хүснэгт 35. Хамгаалалтын бүс

Төрөл		Хамгаалалтын бүсийн төрөл	Хамгаалалтын бүсийн өргөн /м/	Эрх зүйн баримт бичиг
Усны сан бүхий газар	Гол	Онцгой	100	МУ-ын “Усны тухай” хууль, БОАЖ-ын сайд ЭМ-ийн сайд нарын 2009 оны 51/75дугаар хамтарсан тушаалын 1-р хавсралт “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”
		Энгийн	200	
	Нуур	Онцгой	100	
		Энгийн	200	
	Булаг	Онцгой	50	
		Энгийн	200	
	Худаг	Эрүүл ахуйн хамгаалалтын	50	
		Эрүүл ахуйн хязгаарлалтын	200	
Зам, шугам сүлжээний газар	Эрчим хүчний шугам	Хамгаалалтын бүс	10	“Харилцаа холбооны тухай хууль”, ЗГ-ын 2001 оны 263-р тогтоол
	Холбоо, мэдээлэл дамжуулах шугам	Хамгаалалтын бүс	10	
	Орон нутгийн чанартай авто зам	Зурвас газар	60	МУ-ын “Авто замын тухай” хууль

5.2.1. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

Сэлэнгэ мөрөн, түүнд цутгаж буй Харлагийн гол, Тариахтайн гол, Харцайн гол, Шавартайн гол, Баруун хайлантайн гол, Зүүн хайлантайн гол, Дунд хайлантайн гол, Баруун цүүцийн гол, Зүүн цүүцийн гол, Ингэт гол, Бухын гол, бусад жижиг гол, горхиудын онцгой хамгаалалтын бүсийг 100 метр, энгийн хамгаалалтын бүсийг 200 метр, 17 булгийн онцгой хамгаалалтын бүсийг 50 метр, энгийн хамгаалалтын бүсийг 200 метрээр тус тус төлөвлөсөн. Тус сумын нутагт байгаа 29 худгийн эрүүл ахуйн

хамгаалалтын бүсийг 50 метр, хязгаарлалтын бүсийг 200 метрээр төлөвлөсөн /Хүснэгт 36/.

Хүснэгт 36. Усны хамгаалалтын бүсүүд, талбай

Төрөл	Хамгаалалтын бүсийн төрөл	Хамгаалалтын бүсийн өргөн /м/	Хамгаалалтын бүсийн талбай /га/
Гол	Онцгой	100	15446.0
	Энгийн	200	13251.6
Булаг	Онцгой	100	3.3
	Энгийн	200	44.7
Худаг	Эрүүл ахуйн хамгаалалтын	50	5.1
	Эрүүл ахуйн хязгаарлалтын	200	63.0
Нийт			**28813.6**

“Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”-д усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн зааг, бүсийн дэглэмийг тогтоох бөгөөд уг тогтоосон бүсүүдэд зөвшөөрөх ба хориглох газар ашиглалтын хэлбэрүүдийг дор дурьдсан.

1. Онцгой хамгаалалтын бүсэд зөвшөөрөх газар ашиглалтын хэлбэр. Үүнд:
   - Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн байгууламж барьж ашиглах.
   - Гадаргын усыг ус хангамжийн эх үүсвэрт ашиглах тохиолдолд гадаргын усыг цэвэршүүлэх байгууламж барих.
   - Зураг төсөл нь батлагдаж, эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн усны барилга байгууламж /үерийн хамгаалалт, тохируулгын байгууламж, усан цахилгаан станц гэх мэт/ барих.
   - Ариутгах татуургын байгууламжаас бусад иргэний болон дэд бүтцийн барилга байгууламж /гүүр, зам, усан зогсоол, цэвэр усны шугам сүлжээ, цахилгаан дамжуулах шугам гэх мэт/ барих.
   - Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, гольфоос бусад спорт тоглоомын талбай байгуулах, мод бут сөөг тарих.
   - Гол мөрний эх, ундарга буюу голын эх хэсэгт түүнээс усны хагалбарын хил хүртэлх зайд болон голын уртын дагуу, булаг, шандны эхийн эргэн тойронд болон эхээс доош урсах хэсгийн 2 талын эргээр, нуур, усан сангийн эргээр мал бэлчээх.

- Хяналт-шинжилгээний цооног гаргах, хяналт-шинжилгээ явуулах.

2. Онцгой хамгаалалтын бүсэд **хориглох** газар ашиглалтын хэлбэр. Үүнд:
   - Дээр дурдсанаас бусад бүх төрлийн газар ашиглалтын үйл ажиллагаа явуулах, зуслан, суурьшлын бүс байгуулахыг хориглоно.
3. Энгийн хамгаалалтын бүсэд **хориглох** газар ашиглалтын хэлбэр. Үүнд:
   - Түгээмэл тархалттай ашигт малтмал хайх, олборлох.
   - Мод бут огтлох.
   - Хаягдал бохир усыг цэвэршүүлэх байгууламжгүй буюу ариутгах татуургад холбогдоогүй барилга байгууламж барьж ашиглах.
   - Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис хадгалах, агуулах.
   - Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах.
   - Хог хаягдал, бохирдуулах бодис хаях, хог хаягдлын цэг байршуулах.
   - Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх.
   - Мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах.
   - Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах.
4. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:
   - Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;
   - Ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах;
   - Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;
   - Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;
   - Судалгаа шинжилгээ, унд ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
   - Төвлөрсөн ус хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээтэй газар унд ахуйн зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
   - Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;

- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;
- Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;
- Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;
- Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох;

5. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөхөөс гадна дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:
   - Гадны хүн орох;
   - Авто тээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах;
   - Мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих;

5.2.2. Зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүс

“Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэмд”-д зааснаар холбоо мэдээлэл дамжуулах болон эрчим хүчний сүлжээнд зориулан олгосон хамгаалалтын зурвас газрын өргөнийг 10 метрээр төлөвлөсөн /Хүснэгт 37/.

Хүснэгт 37. Зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүс

Төрөл	Хамгаалалтын бүсийн төрөл	Хамгаалалтын бүсийн өргөн /м/	Хамгаалалтын бүсийн талбай /га/
Холбоо, мэдээлэл дамжуулах	Хамгаалалтын бүс	10	25.2
Эрчим хүчний шугам	Хамгаалалтын бүс	10	33.0
Орон нутгийн чанартай авто зам	Зурвас газар	60	1674.8
Нийт			**1733.0**

Эрчим хүчний хамгаалалтын зурвас газарт дараах үйл ажиллагаа эрхэлж болно. Үүнд:

- Хамгаалалтын зурваст инженерийн шугам сүлжээ барьж байгуулах, авто замын гарц гаргах, газар шорооны ажил гүйцэтгэхдээ эрчим хүчний шугам сүлжээний ашиглалтын байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.
- Хамгаалалтын зурваст эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн горим, ажиллагааг алдагдуулахаар үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно.

- Дулааны шугамд тусгай зориулалтын автомашин, механизмаар ажил, үйлчилгээ явуулах шаардлагын үүднээс түүний дээгүүр өнгөрөх цахилгаан болон холбооны агаарын шугамыг 10 м-ээс доошгүй өндөрт татсан байна.
- Эрчим хүчний шугам сүлжээг шилжүүлэх, түүнд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага гарвал холбогдох зардлыг хүсэлт тавьсан байгууллага хариуцаж, шугам сүлжээний ашиглалт хариуцсан байгууллагын зөвшөөрлөөр түүний хяналтын дор гүйцэтгэнэ.
- Хамгаалалтын зурвас дотор газар дор байрласан инженерийн шугам сүлжээг ашиглагч байгууллага нь уг шугамын байршлын зураглалыг эрчим хүчний хангагч байгууллагад өгсөн байвал зохино.
- Хамгаалалтын зурваст газар шорооны ажил гүйцэтгэсний дараа хамгаалалтын зурвасын талбайг хэвийн байдалд нь оруулан сэргээнэ.



Зураг 20. Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө

5.3. Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө

5.3.1. Бэлчээрийн газрын төлөвлөгөө

Малчид 4 улирлаар нүүдэллэн бэлчээрийг хуваарьтай ашиглаж экологийн тэнцвэрт байдлыг хадгалан мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалж ирсэн мал маллагааны уламжлалт аргатай байсан. Сүүлийн жилүүдэд бэлчээрийг улирлаар нүүдэллэн ашигладаг уламжлалт мал маллагааны арга алдагдсан, малын тоо бэлчээрийн даацаас хэтэрсэн, уур амьсгалын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн нөлөөнөөс болж бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн цөөрч, ургац буурч бэлчээр доройтон экосистемийн тэнцвэрт байдал алдагдаж байна. Үүнээс урьдчилан сэргийлэх буюу багасгах зорилгоор ***“Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”***-нд тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан үзэж бэлчээрийг ашиглах улирлын хуваарийг сумын малчидтай хамтран боловсруулж багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж уг төлөвлөгөөнд тусган оруулсан.

Бэлчээрийн газарт нөлөөлөх хүчин зүйлүүдэд газарзүйн байрлал, газрын гадаргын хэв шинж, байгаль цаг уурын онцлогтой уялдуулан мөн бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ, одоогийн бэлчээр ашиглалтын байдал зэргийг харгалзан үзэж бэлчээрийн ашиглалтын улирлын хуваарийг 6 хэв шинжид хуваасан /Хүснэгт 38, Зураг 21/.

Хүснэгт 38. Бэлчээрийн ашиглалтын улирлын хуваарь, талбай

№	Улирлын хуиар	Багийн нэр					Талбай /га/
		Таримал	Тариахтай	Сэлэнгэбүрэн	Атар	Ингэт	
1	Дөрвөн улирал	7025.7	-	8600.8	-	5401.3	21027.7
2	Зун	-	4178.3	8170.8	-	-	12349.0
3	Зун-намар	21949.5	-	-	25033.0	15879.7	62862.3
4	Өвөл	-	27015.1	-	-	-	27015.1
5	Өвөл-намар	-	27493.9	-	-	-	27493.9
6	Өвөл-хавар	-	-	38793.4	9816.8	19165.2	67775.5
7	Хавар	19871.9	-	-	-	4145.2	24017.2
8	Отрын бүс нутаг	6839.8	-	-	-	-	6839.8
Дүн		55686.9	58687.2	55565.0	34849.8	44591.5	249554.3

График 11. Бэлчээрийн ашиглалтын улирлын хуваарь, эзлэх хувь



Бэлчээрийн ашиглалтын улирлын улирлын хуваарийн төрлүүд. Үүнд:

1. **Өвлийн бэлчээр.** Энэ бэлчээрийг Тарихтай багийн нутгийн хойд хэсэгт орших Хантай нуруу, Нарийн ам орчмын газрууд, Харцайн голын хөндий түүний зүүн талаар орших Цагаан толгой, Хөндийн уул, Бонон толгой, Довжоот уул, Нарст толгой орчмын газруудад сонгосон. Өвлийн улирал нь агаарын температур хамгийн хүйтэн, бэлчээрийн ургамлын шим муудаж, хагдарч унасан, цасанд дарагдсан, ил задгай усгүй болсон хамгийн ширүүн улирал юм. Иймд өвлийн бэлчээрийг салхи багатай нөмөр нөөлөгтэй, нимгэн цас унадаг, үетэн ургамал зонхилсон, уул толгодын өвөр энгэр ээвэр болон дэрс буттай хотгор газруудад сонгосон.
2. **Хаврын бэлчээр**. Таримал, Ингэт багийн нутгийн хойд хэсэгт Сэлэнгэ мөрнөөс урагшаа Ихтийн адгийн тал, Ихтийн нуруу, Тарималын нуруу, Шант нуруу, Хуурай уул, Манхан овоо орчмын газруудад сонгосон. Агаарын температур нэмэх градуст шилжиж дулаарах боловч огцом хүйтрэх, хүчтэй шуурга тавих зэрэг эрс тэс нөхцөл байнга тохиолдож мал төллөж эхэлдэг. Иймд малчид гарсан төлийг бойжуулахад онцгой анхаардаг учраас хаврын улирлын бэлчээр нь малыг салхинаас нөмөрлөсөн, цас түрүүлж хайлдаг энгэр ээвэр, чийг сайтай, зөөлөн хөрстэй бууцнаасаа холгүй газрыг сонгоно.
3. **Өвөл-хавар, өвөл-намрын бэлчээр.** Энэ бэлчээрийг Таримал, Сэлэнгэбүрэн, Атар багийн нутагт сонгосон. Таримал багийн нутгийн хойд хэсэгт Ингэтийн гол, Могойн гол, Цагаан Устын голуудын хөндий, Ханан хаалгачийн нуруу бүхэлдээ,

Сэлэнгэбүрэн багийн нутгийн өмнөд хэсгээр Сэлэнгэ мөрнөөс хойш Шаврын эрээний нуруу, Хоолын нуруу, Дунд нуруу орчмын газрууд, Ингэт багийн нутагт орших Бүрэн толгой, Хүүхэд толгой орчмын газруудыг сонгосон. Өвөл-хавар болон өвөл-намрын улиралд дараалан нутаглах боломжтой өвөл хаврын бэлчээрийн төрх, нөхцөлийг хангасан газрыг сонгоно.

4. **Зуслан.** Тариахтай, Сэлэнгэбүрэн багийн нутагт Сэлэнгэ мөрөнд цутгаж буй Шавартын голын хөндий, Эрээн мод толгой түүний урд энгэр болон Ханлзан морьтын дэнж зэрэг газруудыг зуслан буюу зуны бэлчээрээр сонгосон.
5. **Зун-намрын бэлчээр.** Атар багийн нутагт орших Хулстайн даваа, Баян цагаан уул, Хар модотын даваа, Гогот уул, Өндөр овоот толгой, Таримал, Ингэт багийн нутагт орших Зүүн бухын нуруу, Баруун бухын нуруу, Хойд билүүт ам, Дунд билүүт ам, Урд билүүт ам, Бэрх, Ингэт зэрэг голын хөндийгөөр зун-намрын бэлчээрийг сонгосон. Зун-намрын улиралд дараалан нутаглах боломжтой зун намрын бэлчээрийн, нөхцөлийг хангасан газрыг сонгоно.
6. **4 улирлын бэлчээр.** Сэлэнгэ мөрнөөс хойш Сэлэнгэбүрэн багийн нутагт орших Их хайлантайн голын хөндий, Таримал багийн нутгийн урд хэсгийн Бух, Улаан бугат зэрэг голын хөндий орчмын газарт 4-н улирлын бэлчээрийг сонгосон. Сүүлийн жилүүдэд төв суурин газарлуу шилжих хөдөлгөөн нэмэгдэж бэлчээрийн сэлгээ хийх нөөц хомсдсон, нөгөөтэйгүүр малчид маань нэг газраа төвхнөж цөөн тооны ашиг шим өндөртэй малтай өрх нэмэгдсэн зэрэг шалтгаанаас болж нэг дооров жил тойрон нутаглах болсон. Иймд 4 улиралд ашиглах боломжтой нөхцөл бүрдсэн газрыг сонгоно.

Хүснэгт 39. Улирлын бэлчээр багтаамж, даац

Баг	Улирлын бэлчээр	Багтаамж хон.тол	Талбай, га	Га-ийн ургац, цн	Тэжээлийн нөөц, цн	Хонь жилд идэх өвс, цн	Багтаамж, хонин толгой	Даац, хувь
Таримал	Хавар	25191.7	19871.9	4.6	91410.8	6	15235.1	165.4
	Зун-намар	34462.3	21949.5	4.6	100967.9	6	16828.0	204.8
	Дөрвөн улирал	7825.6	7025.7	4.6	32318.0	6	5386.3	145.3
Тариахтай	Өвөл	13611.5	18301.7	4.6	84187.7	6	14031.3	97.0
	Өвөл-намар	29788.0	27493.9	4.6	126471.9	6	21078.6	141.3
	Зун	20397.1	4178.3	4.6	19220.0	6	3203.3	636.7
	Өвөл	7033.2	8713.4	4.6	40081.6	6	6680.3	105.3
Сэлэнгэбүрэн	Өвөл-хавар	5103.2	16091.1	4.6	74018.8	6	12336.5	41.4
	Зун	9273.8	1292.0	4.6	5943.0	6	990.5	936.3
	Дөрвөн улирал	4185.9	8600.8	4.6	39563.6	6	6593.9	63.5

	Өвөл-хавар	34957.0	22702.4	4.6	104431.0	6	17405.2	200.8
	Зун	1241.5	5265.6	4.6	24221.6	6	4036.9	30.8
	Зун	1110.6	1613.3	4.6	7421.0	6	1236.8	89.8
Атар	Өвөл-хавар	7977.4	9816.8	4.6	45157.2	6	7526.2	106.0
	Зун-намар	8986.3	25033.0	4.6	115151.7	6	19192.0	46.8
Ингэт	Хавар	216.9	4145.2	4.6	19068.1	6	3178.0	6.8
	Өвөл-хавар	18959.6	19165.2	4.6	88160.1	6	14693.3	129.0
	Зун-намар	22169.1	15879.7	4.6	73046.8	6	12174.5	182.1
	Дөрвөн улирал	1105.6	5401.3	4.6	24845.8	6	4141.0	26.7

График 12. Улирлын бэлчээрийн даац



Дээрх графикаас үзэхэд:

- Сэлэнгэбүрэн багийн Сэлэнгэ мөрний эрэг орчмын 1.3 мянган га зуслан буюу зуны бэлчээрийн даац 936.3 хувь буюу 9 дахин, Тариахтай багийн Эрээн мод толгой түүний урд энгэр Ханлзан морьтын дэнж, Шавартай голын хөндийн орчмын зуны бэлчээрийн даац 636.7 хувь 6 дахин хэтэрсэн байна.
- Таримал багийн урд хэсгийн Зүүн бухын нуруу, Баруун бухын нуруу орчмын зун-намрын бэлчээр, Сэлэнгэбүрэн багийн Зүүн хайлантайн гол, Дунд хайлантайн гол, Нарийн гол, Баян гол орчмын өвөл-хаврын бэлчээрийн 200.8-204.8 хувь буюу 2 дахин хэтэрсэн байна.
- Таримал багийн хавар, 4-н улирар, Тариахтай багийн өвөл-намрын, Ингэт багийн өвөл-хаврын, зун-намрын бэлчээрийн даац 1.3-1.8 дахин хэтэрсэн байна.



Зураг 21. Бэлчээр ашиглалтын улирлын төлөвлөгөө



Зураг 22. Улирлын бэлчээрийн ашиглалтын даац

5.3.2. Бэлчээрийн ашиглалтын хэсгийн төлөвлөгөө

Монгол Улсын Газрын тухай хуулийн 52.2-т заасан ***“Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдлаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, даац, чадавхийг харгалзан, Багийн Иргэдийн нийтийн хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно”*** гэсэн заалтын үндэслэн гэрээгээр бэлчээр ашиглах боломжтой малчдын хуваарийг гаргаж, төлөвлөсөн.

Бэлчээрийн газар ашиглалт нь сумын үндсэн газар ашиглалт байгаа бөгөөд цаашид бэлчээрийг өнө удаан хугацаанд тогтвортой ашиглахын тулд улирлын сэлгээг сайн хийх, бэлчээрийн даац багтаамжид тааруулж малаа өсгөх, бэлчээрийг доройтохоос хамгаалах, тордох, нөхөн сэргээх, эзэнтэй болгох шаардлагатай. Иймд бид энэхүү нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын хэсгийг нутгийн малчдын саналын үндсэн дээр тогтоосон ба Багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж тогтоосон болно.

Сумын хэмжээнд бэлчээр ашиглалтын 38 хэсгийг тогтоож, хэсэг бүрийн бэлчээрийн багтаамж, даацийг дараах хүснэгтэд үзүүлэв /Хүснэгт 40/.

Хүснэгт 40. Бэлчээр ашиглалтын хэсгийн багтаамж, даац

Хэсэг дугаар	Багтаамж хон.толгой	Талбай, га	Га-ийн ургац, цн	Тэжээлийн нөөц, цн	Хонь жилд идэх өвс, цн	Багтаамж, хонин толгой	Даац, хувь
1	8986.3	5265.6	4.6	24221.6	6	4036.9	222.6
2	1241.5	25033.0	4.2	105138.5	6	17523.1	7.1
3	2714.7	6320.6	4.2	26546.5	6	4424.4	61.4
4	5262.7	3496.2	4.2	14684.1	6	2447.3	215.0
5		5437.1	4.6	25010.6	6	4168.4	
6	8481.5	2711.9	4.6	12474.5	6	2079.1	407.9
7	13625.3	1966.0	4.6	9043.8	6	1507.3	904.0
8	5030.2	2887.1	4.6	13280.5	6	2213.4	227.3
9	2413.1	2724.5	4.6	12532.5	6	2088.7	115.5
10	3143.4	3729.6	4.6	17156.3	6	2859.4	109.9
11	2263.5	3246.3	4.6	14932.8	6	2488.8	90.9
12	4185.9	8600.8	4.6	39563.6	6	6593.9	63.5
13	9273.8	1292.0	4.6	5943.0	6	990.5	936.3
14	4135.2	10320.9	4.6	47476.4	6	7912.7	52.3
15	968	5770.1	4.6	26542.5	6	4423.7	21.9
16	7033.2	8713.4	5.3	46180.9	6	7696.8	91.4

17	1110.6	1613.3	4.6	7421.0	6	1236.8	89.8
18	20397.1	4178.3	5.3	22144.7	6	3690.8	552.6
19	2749.3	4766.2	5.3	25260.9	6	4210.2	65.3
20	2938.5	11159.4	5.3	59144.6	6	9857.4	29.8
21	11920.2	4848.8	5.3	25698.6	6	4283.1	278.3
22	12180	6719.5	5.3	35613.5	6	5935.6	205.2
23	1110	8848.4	5.3	46896.3	6	7816.1	14.2
24	6130.7	4887.0	5.3	25900.9	6	4316.8	142.0
25	6370.8	4566.3	5.3	24201.6	6	4033.6	157.9
26		6839.8	5.3		6		
27	14593.8	8204.9	5.0	41024.3	6	6837.4	213.4
28	10597.9	11667.1	5.0	58335.5	6	9722.6	109.0
29		394.4	4.4		6		
30	216.9	3924.8	4.4	17269.0	6	2878.2	7.5
31	3287.4	1489.1	4.4	6552.3	6	1092.0	301.0
32	10346.8	6609.5	4.4	29082.0	6	4847.0	213.5
33		5790.8	4.4		6		
34	5325.4	5275.8	4.4	23213.4	6	3868.9	137.6
35	34462.3	21949.5	5.0	109747.7	6	18291.3	188.4
36	22169.1	15879.7	4.4	69870.9	6	11645.1	190.4
37	7825.6	7025.7	5.0	35128.3	6	5854.7	133.7
38	1105.6	5401.3	4.4	23765.5	6	3960.9	27.9

Бэлчээр ашиглалтын хэсэгт байгаа өрхүүд бэлчээрийн сэлгээг тогтсон цагт товлон хэсгийн ахлагч, нэрийг Багийн иргэдийн нийтийн хурлаар шийдвэрлэх боломжтой. Иймд цаашид бэлчээрийн даацыг багтаамжид тааруулан бэлчээрийг гэрээгээр ашиглах нь зүйтэй.

Бэлчээрийн ашиглалтын хэсэг байгуулснаар дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Бэлчээр “эзэнтэй” болж, зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах хөшүүрэг бий болно.
2. Малын тоог бэлчээрийн даацтай уялдуулснаар зөвхөн малын тоог өсгөх биш харин харин эдийн засгийн эргэлтэд оруулан борлуулах, ашиг шим, чанарыг эрхэмлэх сэтгэлгээ төлөвшинө.
3. Мал аж ахуйг чанар, бүтээмжид суурилсан тогтвортой хөгжлийн гулдралд оруулж, МАА-н өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангаж, үнийн өсөлтөөс сэргийлнэ.
4. Бэлчээрийн эдэлбэрээс бусад эдэлбэрт шилжихэд малчид, нутгийн захиргаа, мал аж ахуйн салбарын эрх ашгийг зохистой харгалздаг нөхцөлийг бүрдүүлнэ.

5. Бэлчээрийн унаган төрхийг сэргээн хадгалж, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр зах зээлд өрсөлдөж, эдийн засгийг солонгоруулах гарцыг нээнэ.



Зураг 23.Бэлчээрийн ашиглалтын хэсгийн төлөвлөгөө



Зураг 24. Бэлчээр ашиглалтын хэсгийн даац

5.3.3. Хадлангийн газрын төлөвлөгөө

Сумын хэмжээнд шинээр хадлан эрхлэхэд боломжтой хөрс, ургамлан нөмрөг бүхий газрууд тохиромжтой байдлын үнэлгээгээр тодорхойлогдсон боловч хээрийн хэмжилт судалгаа, иргэдийн санал, орон нутгийн мэргэжилтэн удирдлагуудын санал хэлэлцүүлгийг үндэслэн нийт 4.8 мянган га талбайд хадлангийн газар төлөвлөсөн /Хүснэгт 41, Зураг 25/.

Хүснэгт 41. Хадлангийн газрын төлөвлөгөө, байршил

Багийн нэр	**Газрын нэр**	**Талбай /га/**	**Эзлэх хувь**
Тариахтай	Нарангийн гол	215.2	**40.5**
	Нарст толгой	145.9	
	Өндөр дэлгэр уулын урд дэнж	1.2	
	Тарвагатай нуга	80.9	
	Тариахтай гол	521.5	
	Харлагийн гол	493.6	
	Харцайн гол	461.5	
	Шавартын гол	21.5	
Нийт		1941.4	
Таримал	Бухын гол	140.9	**8.0**
	Бэрхийн гол	113.2	
	Тарималын гол	129.8	
Нийт		383.9	
Сэлэнгэбүрэн	-	0.7	**25.7**
	Галсан толгой	258.2	
	Дунд хайлантайн гол	98.9	
	Зүүн хайлантайнгол	261.4	
	Их арал	162.8	
	Таван толгой	165.9	
	Шавартын гол	146.9	
	Шар чулуут уул	138.7	
Нийт		1233.5	
Атар	Баруун цүүцийн гол	131.1	**17.2**
	Зүүн цүүцийн гол	577.8	
	Цүүцийн гол	118.1	
Нийт		827.0	
Ингэт	Тарималын гол	190.5	**8.6**
	Цагаан устын гол	222.3	
Нийт		412.8	
Дүн		**4798.6**	**100**



Зураг 25. Хадлангийн газрын төлөвлөгөө

5.3.4. ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборт газрын төлөвлөгөө

Монгол Улсын ***“Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай”*** хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 160-р тогтоолоор баталсан ***“Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх хөтөлбөр”***-ийг тус тус үндэслэн мөн хот суурин газрын хүн амыг аюулгүй хүнс, тэжээлээр хангах хэрэгцээ шаардлагын улмаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр засгаас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд тус сумын Таримал багийн Цагаан тохой нэртэй газарт малын тэжээл тарих зориоготой 1 га талбай, мөн Сэлэнгэ үүлдэрийн үхрийг түшиглэн махны чиглэлийн мал бэлтгэх зорилгоор мал бордох 5-н төвийг тус тус төлөвлөсөн.

Мөн Таримал, Ингэт, Сэлэнгэбүрэн, Атар багийн нутагт 8 байршилд зөгийн үржүүлгийн газрыг төлөвлөсөн /Хүснэгт 42, Зураг 26/.

Хүснэгт 42. ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборт газрын төлөвлөгөө

№	Багийн нэр	Газрын нэр	Төрөл	Байршлын солбицол	
				X	Y
1	Таримал	Цагаан тохой	Мал бордох цэг	49° 25' 27.9" N	49° 25' 27.9" N
2	Таримал	Цагаан тохой		49° 24' 57.4" N	49° 24' 57.4" N
3	Таримал	Цагаан тохой		49° 24' 43.1" N	49° 24' 43.1" N
4	Таримал	Цагаан тохой		49° 23' 47.4" N	49° 23' 47.4" N
5	Таримал	Цагаан тохой		49° 23' 44.3" N	49° 23' 44.3" N
6	Таримал	Цагаан тохой	Зөгий үржүүлгийн газар	49° 25' 1.4" N	49° 25' 1.3" N
7	Таримал	Ихтийн адагийн тал		49° 27' 27.7" N	49° 27' 27.7" N
8	Ингэт	Хараатын ар		49° 26' 47.6" N	49° 26' 47.6" N
9	Сэлэнгэбүрэн	Дүгрээгийн нуга		49° 27' 29.9" N	49° 27' 29.9" N
10	Сэлэнгэбүрэн	Их арал		49° 30' 32.4" N	49° 30' 32.4" N
11	Атар	Хужирт нуга		49° 41' 30.7" N	49° 41' 30.7" N
12	Таримал	Эг-Сэлэнгийн бэлчир		49° 22' 58.2" N	49° 22' 58.2" N
13	Таримал	Цагаан тохой		49° 24' 46.7" N	49° 24' 46.7" N



Зураг 26. ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборт газрын төлөвлөгөө

5.4. Хот, тосгон бусад суурин газрын төлөвлөгөө

5.4.1. Суурин газрын төлөвөгөө

Сэлэнгэ сум нь 2016 оны байдлаар нийт 3306 хүн амтай байна. Сэлэнгэ сумын төвд Таримал болон Ингэт багийн төвүүд төвлөрдөг тус багуудын нийт хүн ам 1885, Тариахтай баг 585, Сэлэнэгэбүрэн баг 483, Атар баг 410 хүн амтай байна.

Иймээс сумын төвийн хүн амын хэт их төвлөрлийг сааруулах зорилгоор бусад багуудад хүн амьдрах таатай орчин нөхцөл бүрдүүлэх, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой чиглэлээр төрөлжүүлэн эрчимтэй хөгжүүлэх, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай.

Тус сумын Тарихтай болон Сэлэнгэбүрэн багийн төвүүд суурьшил үүссэн боловч суурьшлын газрын талбайн хэмжээ нь газрын нэгдмэл сангийн ангиллын ХАА-н газрын бэлчээрийн газарт тооцогддог байсан. Иймд тус багуудын суурьшлын бүсийн тэг гортигийг татаж, талбайн хэмжээг тодорхойлж, газрын нэгдмэл сангийн хот, тосгон бусад суурины ангиллын газарт нэмж бүртгэхээр төлөвлөсөн /Хүснэгт 43, Зураг 27/.

Хүснэгт 43.

Багийн нэр	Газрын нэр	Талбай /га/
Сэлэнгэбүрэн	Хялганатын нуга	316.4
Тарихтай	Сэлэнгэ-Тариахтай голын бэлчир	286.6
Нийт		**603.0**

Сумын сумын Атар багийн төв нь сумын нутаг дэвсгэрийн хилийн заагийн гадна буюу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын нутагт байрладаг. Иймээс тус сумын шинээр байгуулах хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээг үндэслэн Атар багийн нутаг дэвсгэрийн урд хэсэгт орших Хадат толгойн зүүн ам, Зүүн цүцийн голын баруун эргээр, Сантын овоо нэртэй газрын баруун хойд хэсэгт 276.4 га талбайд Атар багийн төв байхаар төлөвлөсөн /Зураг 28/.



Зураг 27. Хот суурин газрын төлөвлөгөө

5.4.2. Аялал жуулчлалын газрын төлөвлөгөө

Сэлэнгэ сумын аялал рекреацын газрын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилан сумын иргэд, олон нийтийн саналыг үндэслэн сумын аялал жуучлалын 2 маршрутыг төлөвлөсөн /Хүснэгт 44, Зураг 28/.

Хүснэгт 44. Аялалын маршрут

Маршрут	Төрөл	Чиглэл	Урт /км/
1	Аялал	Сумын төв – Бэрхийн ам	65.7
2	Усан аялал буюу загасчлал	Сэлэнгэ мөрөн дагуу	42.6

1. Аялалын маршрут. Сумын төв – Бэрхийн ам чиглэлд 65.7 км урттай замаар аялана. Харганатын гозгор /1389 м/ хэмээх ой модтой, байгалийн үзэсгэлэнт уулын баруун энгэрт байрлах Цагаан хустын адгийн бичигт чулуу, Шашин толгой дахь бурханы хөрөг, Бага хөх чулуутын ходоодны рашаан зэрэг байгалийн үзэсгэлэнт болон түүх дурсгалын газруудыг үзэж сонирхоно.
2. Усан аялал буюу загасчлал. Сэлэнгэ мөрөн дагуу 42.6 км урт замаар аялана. Зуны улиралд моторт болон сэлүүрт завь, рафт буюу хийлдэг завиар аялах, загасчлах, мэргэжлийн аялагч нарт зориулж каяак болон каное завийн спортыг хөгжүүлэх, өвлийн улиралд цана, тэшүүрийн спортыг хөгжүүлэх боломжтой.

Бага хөх чулуутын ходоодны рашааныг түшиглэн Хоод амралтын газар, Сэлэнгэ мөрний дагуу Эг-Сэлэнгийн бэлчир, Хөх хошуу-Данган сайр, сумын төв, Рашааны хөл, Цүцийн гол зэрэг газарт жуулчны бааз буюу усан аяллын түр зогсоолын газруудыг төлөвлөж, орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулна /Хүснэгт 45/.

Хүснэгт 45. Төлөвлөж буй жуулчны бааз, зогсоолын байршил

№	Багийн нэр	Төрөл	Газрын нэр	Байршлын солбицол	
				X	Y
1	Ингэт	Жуулчны бааз	Хоод амралт	49° 15' 41.9" N	104° 2' 30.5" E
2	Таримал	Түр зогсоол	Энх-Сэлэнгэ бэлчир	49° 23' 9.8" N	103° 37' 41.7" E
3			Хөх хошуу-Данган сайр	49° 25' 38.2" N	103° 46' 52.4" E
4			Сумын төв	49° 27' 47.6" N	103° 58' 14.4" E
5	Сэлэнгэбүрэн		Рашааны хөл	49° 27' 57.3" N	104° 8' 58.0" E
6			Цүцийн гол	49° 28' 49.2" N	104° 18' 17.5" E



Нэгж талбарын дугаар	Зорилгын ангилал	Талбай /м2/	Газрын нэр	Огноо
63002001435	Аялал, амралт зугаалга	99.9	Хоод рашаан	2011/11/14
63002003158	Аялал, амралт зугаалга	156.8	Борхийн ам	2014/09/22
63002001440	Аялал, амралт зугаалга	505.0	Даваийн сайр	2007/12/29
63002003159	Аялал, амралт зугаалга	104.2	Дүүрэгээ нуга	2014/09/22
63002003248	Аялал, амралт зугаалга	101.4	Хуажийн адаг	2016/01/07
63002001438	Аялал, амралт зугаалга	355.3	Эг Сэлэнгийн бэлчир	2017/09/28
63002001439	Аялал, амралт зугаалга	247.5	Эг Сэлэнгийн бэлчир	2017/09/29
63002003160	Аялал, амралт зугаалга	214.7	Зуны гол	2014/09/22
63002003255	Аялал, амралт зугаалга	101.1	Баянцагааны урд эргэр	2015/11/02
63002001442	Жимс жимсгэнэ	826.5	Ваагын хад	2017/05/23
63002001441	Жимс жимсгэнэ	206.3	Уланцы жалга	2012/02/12
63002003033	Жимс жимсгэнэ	71.0	Инэгэлийн гол	2017/09/28
63002003140	Жимс жимсгэнэ	503.4	Ваагын хад	2013/11/27
63002003139	Жимс жимсгэнэ	335.4	Тооройн гарам	2013/11/18
63002003251	Загас, мод үржүүлэг	1521.4	Хартайн адаг	2016/04/20
63002003258	Загас, мод үржүүлэг	492.1	Хар эрэг	2015/11/02

Зураг 28. Аялал жуулчлалын газрын төлөвлөгөө

5.5. Зам, шугам сүлжээний газрын төлөвлөгөө

5.5.1. Авто замын газрын төлөвлөгөө

Нутгийн иргэдийн санал, мөн иргэдийн хэрэгцээт байдлын үнэлгээ болон авто замын газрын тохиромжтой байдлын үнэлгээ зэргийг үндэслэн тус суманд нийт 1.8 мянган га талбайд 188.9 км авто зам төлөвлөсөн /Хүснэгт 46/.

Хүснэгт 46. Авто замын газрын төлөвлөгөө

№	Замын төрөл	Замын чиглэл	Замын урт /км/	Хамгаалалтын зурвас	
				Өргөн /м/	Талбай /га/
1	Сайжруулсан шороон	Тариахтай баг-Тэшиг сум	30.0	60	180.0
2	Хатуу хучилттай авто	Эрдэнэт-Сумын төв	41.1	100	411.3
3		Сумын төв-Эг, Сэлэнгийн бэлчир	26.8		268.0
4		Сумын төв-Тариахтай баг	4.0		40.0
5		Тариахтай баг-Хийдийн даваа	20.3		203.0
6		Тариахтай баг-Атар баг	66.7		667.0
Нийт			**188.9**	**-**	**1769.3**

5.5.2. Гүүр барих, даваа засах газрын төлөвлөгөө

Тус сумын нутгийн төв хэсгээр Сэлэнгэ мөрөн урсан өнгөрдөг, түүнд цутгадаг болон түүнээс салбарлан урсдаг том, жижиг голууд олон байдаг учир голыг гатлах боломж муу, намаг, шалбааг ихтэй, эрсдэл их дагуулж байдаг. Иймд нутгийн иргэдийн санал, мөн иргэдийн хэрэгцээт байдлын үнэлгээ болон тохиромжтой байдлын үнэлгээнд тулгуурлан гүүр шинээр барих, үер усны гамшигаас болж эвдэрч сүйтсэн овоо, даваа засах шаардлага гарч байна.

Дээрх шаардлагыг үндэслэн дараах газруудад гүүр барих, даваа болон бартаатай авто замыг засах төлөвлөгөөг боловсруулсан /Хүснэгт 47/. Үүнд:

- Сэлэнгэ-Бухын голын бэлчир болох Манхан овоо, Сэлэнгэ-Харлангийн голын бэлчир болон Олон булаг орчмын газрууд нь дулаан үе ирхээр газар гэсэж, цас, мөс хайлж намаг, балчигтай болдог учир тээврийн хэрэгсэл болон нутгийн иргэд зорчиход хүндрэл учирдаг.
- Таримал болон Ингэт багийн заагт орших Бухын даваа нь үерийн усны улмаас эвдэрч, тээврийн хэрэгсэл зорчиход хүндрэлтэй болсон.

Гэхдээ гүүр барих нийгэм-эдийн засгийн тооцоо, судалгааг мэргэжлийн түвшинд нарийвчлан тогтоож, эдийн засгийн үр өгөөжийг судлах шаардлагатай байна.

Хүснэгт 47. Даваа засах, гүүр барих газрын байршил, солбицол

Багийн нэр	Газрын нэр	Төрөл	Байршлын солбицол	
			X	Y
Таримал	Манхан овоо	Гүүр тавих	49° 24' 27.0" N	103° 47' 13.6" E
Тариахтай	Олон булаг	Гүүр тавих	49° 28' 49.8" N	103° 52' 19.6" E
Таримал, Ингэт	Бухын даваа	Даваа засах	49° 07' 25.6" N	103° 57' 05.9" E



Зураг 29. Авто замын газрын төлөвлөгөө

5.6. Тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөө

Сэлэнгэ суманд улсын тусгай хамгаалалттай газар буюу **“Зэд, Хантай, Бүтээлийн нуруу”** ДЦГазар 174.5 мянган га, улсын хилийн зурвас газар 65.0 мянган га талбайг тус тус эзэлдэг.

УИХ-ын 2011 оны 05-р сарын 05-ны 18 тоот тогтоолоор Булган аймгийн Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумдын нутгийг дамнан орших Зэд-Хантай-Бүтээлийн нурууд, тэдгээрийн орчмын газар нутгийг дархан цаазат газрын ангилалд бүртгэн авсан. **“Зэд, Хантай, Бүтээлийн нуруу”** ДЦГазар нь тус сумын Тариахтай, Сэлэнгэбүрэн, Атар багийн нутаг дэвсгэрийн Сэлэнгэ мөрнөөс хойш ойт хээрийн дундаж өндөр уулс бүхий 174.5 мянган га талбай буюу нийт нутаг дэвсгэрийн 37.1 хувийг эзэлж байгаагаас болж дээрх багууд нь мал бэлчээрлэх газар хомстож, бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр ургамлан нөмрөг доройтолд орж байна.

Иймд дээрх шалтгааны улмаас орон нутгийн удирдлага, малчид, ард иргэдийн санал хүсэлт, хэрэгцээ, шаардлагын дагуу **“Зэд, Хантай, Бүтээлийн нуруу”** ДЦГазраас 59400 га талбайг хасаж улсын тусгай хэрэгцээний газрын төлөвлөсөн /Зураг 30/.



Зураг 30. Тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөө

5.7. Зүй ёсны эрхээр ашиглах нутаг дэвсгэрийн төлөвлөгөө

Зүй ёсны эрх гэж уламжлалт мал аж ахуйд голлон түшиглэж тухайн нутаг дэвсгэр дахь байгалийн бүхий л төрлийн нөөцийг түүний нөхцөлд дасан зохицож, арвижуулан, өсгөж, хамгаалж, зүй зохистойгоор хэрэглэж ирсэн хараахан баталгаажаагүй байгаа уламжлалт эрх, албан бус эрх (төрийн болон иргэдийн хэрэглэж буй эрхүүд), тэдгээрийн дагалдан үүсэх эрхүүдийг хэлнэ.

Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 21 өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан “Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар нь бүртгэн, баталгаажуулах түр заавар”-ын дагуу Сэлэнгэ суманд дараах байгалийн нөөц, эдэлбэрийн зүй ёсны эрх үүсч түүнийг баталгаажуулах боломжтой гэж төлөвлөсөн. Үүнд:

1. **Бэлчээрийн нөөцийг ашиглах, хамгаалах.** Уламжлалт мал аж ахуй эрхэлдэг бөгөөд албан ёсоор баталгаажсан малчдын бүлэг, нөхөрлөл, хэсэг, ой хамгаалах нөхөрлөл байхгүй байна. Иймд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан бэлчээр ашиглалтын 38 хэсгийг түшиглэн уг эрхийг баталгаажуулах боломжтой юм. Тус бэлчээр ашиглалтын 38 хэсэг нь уламжлалт мал аж ахуйгаа эрхлэхийн зэрэгцээ өөрийн бэлчээр нутгийн орчмын байгалийн бүхий л төрлийн нөөцийг хамгаалж түүнд дасан зохицож, арвижуулан, өсгөж зүй зохистойгоор хэрэглэж зүй ёсны эрхээ баталгаажуулах юм. Зүй ёсны эрхийг баталгаажуулахдаа “Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар нь бүртгэн, баталгаажуулах гэрээ”-г зүй ёсны эрх эдлэгч ба мэргэжлийн багийн хамт байгуулна.
2. **Ан амьтан хамгаалах, ашиглах.** Тус сумын нутагт ховор болон ховордож байгаа ан амьтад их тул түүнийг хамгаалж, өсгөх;
3. Эрчимжсэн аж ахуй эрхлэх;
4. Орон нутгийн онцлогоос хамаарсан бусад эрхүүд;

Дээрх зүй ёсны эрхийг тус сумын нутагт баталгаажуулах боломжтой юм. Иймээс зүй ёсны эрх эдлэгч нь мэргэжлийн багтай гэрээ байгуулж эрхээ баталгаажуулна.

Мэргэжлийн баг гэж газар байгалийн нөөцийг ашиглан хамгаалах,е хадлан, бэлчээр ашиглуулах, хамгаалах зэрэг иргэдийг зүй ёсны эрх эдлэхэд нь зөвлөх, туслах, хянах үүрэг бүхий сумын Засаг даргын томилсон орон нутгийн мэргэжилтнүүдийг байна. Үүнд газрын даамал, байгаль орчны байцаагч, ХАА-н мэргэжилтэн, байгаль

хамгаалагч, багийн Засаг дарга гэх мэт. Зүй ёсны эрх эдлэгч гэж иргэд, малчид, малчдын бүлэг, хот айл, нөхөрлөл, хоршоод, ААНБ, ТББ, болон иргэд хоорондоо сайн дурын үндсэн дээр нэгдэж зохион байгуулалтад орсон бусад хэлбэрийн нэгдлүүдийг хэлнэ.



Зураг 31. Зүй ёсны эрхээр баталгаажуулах төлөвлөгөө

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө нь сумын хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох үндсэн баримт бичиг болно. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн иргэд, засаг газрын тамгын газрын бүрэлдэхүүн болон сумын иргэдийн төлөөлөгчид идэвхтэй оролцож сумын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон, баталгаажуулсан. Иймээс сумын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа сумын нутаг дэвсгэрийн суурь судалгааны болон сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний баримт бичигт тусгасан төлөвлөгөөг мөрдөж ажиллах шаардлагатай.

Сумын нутаг дэвсгэрийн суурь судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийсний үндсэн дээр сумын газрын тохиромжтой байдлын үнэлгээг газар ашиглалтын төрөл бүрээр тодорхройлж, нутаг дэвсгэрийг зөв зохистой ашиглах, төлөвлөх боломжийг бий болгож өгсөн. Тохиромжтой гэж үзсэн ангилал тус бүрт цаашид тохиромжтой ангилал бүрээр газрыг ашиглах хэрэгцээтэй.

Сумын хэрэгцээт байдлын үнэлгээг сумын иргэдээс санал, асуулга явуулж судалгаа хийж тодорхойлсон бөгөөд иргэдийн саналыг газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээтэй харьцуулан сумын **“Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”**-г болорвсруулсан. Уг баримт бичгийг үндэслэн, мөн үүнтэй уялдуулан цаашид сум өөрөө тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд нэг шат ахиж байна. Иймээс энэхүү баримт бичгийг ашиглах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү баримт бичиг нь сумын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд суурь материал болно гэдгийг үргэлж санах хэрэгтэй. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд дараах бодлогын баримт бичгүүдийг нарийн судалж, эдгээр баримт бичигтэй уялдуулсан болно. Үүнд:

- Мянганы хөгжлийн бодлого, аймгийн хөгжлийн бодлого
- Сумын хөгжлийн бодлогод уялдуулах
- Сум хөгжүүлэх чиг хандлага
- Сумын газар нутагтай холбоотой байгалийн төрх байдал нөөцийн судалгаа
- Нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын судалгаа
- Газар ашиглалтын судалгаа
- Газрын нөөц, ашиглалтын үнэлгээ

- Сумын газрын тохиромжтой байдлын үнэлгээ ашиглалтын төрөл бүрээр
- Сумын иргэдийн хэрэгцээт байдлын үнэлгээ
- Бэлчээрийн газрын эдийн засгийн чадавхийн үнэлгээ
- Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө
- Зүй ёсны эрхийн баталгаажуулалт

Төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавина гэдгийг анхаарах хэрэгтэй.

АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын “Газрын тухай” хууль. УБ. 2002 он
2. Монгол Улсын “Авто замын тухай” хууль. УБ. 2017 он
3. Монгол Улсын “Ойн тухай” хууль. УБ. 2012 он
4. Монгол Улсын “Аялал жуулчлалын тухай” хууль. УБ. 2000 он
5. Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хууль. УБ. 2001 он
6. Монгол Улсын “Усны тухай” хууль. УБ. 2012 он
7. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль.
8. Монгол Улсын “Хот байгуулалтын тухай” хууль 1998 он
9. “Аймаг, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар” УБ, 2008 он.
10. “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он.
11. ГЗБГЗЗГ-ын даргын 2017 оны А/278 тоот тушаал “Сумын нутаг дэсвгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”
12. ЗГ-ын 2001 оны 263-р тогтоол “Эрчим хүчний шугам, сүлжээг хамгаалах дүрэм”
13. БОАЖЯ, ЭМЯамны сайд нарын 2009 оны 51/75 дугаар хамтарсан тушаал “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”
14. ГХГЗЗГ-ын даргын А/22 тоот тушаал “Газар, байгалийн нөөц, эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар бүртгэн, баталгаажуулах түр журам” 2016 он.
15. ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаал “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга зүй”
16. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэм. 2004 он
17. Булган аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр 2016-2020
18. Булган аймгийн Сэлэнгэ сумын хөгжлийн цогц бодлого (2011-2121)
19. Булган аймгийн Сэлэнгэ сумын засаг даргын мөрийн хөтөлбөр 2016-2020
20. Булган аймгийн бэлчээрийн хянан баталгааны тайлан
21. Булган аймгийн тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан. 2017 он
22. Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд, Улаанбаатар 2004
23. Т. Энэбиш Монголын бүсчилсэн хөгжлийн онол –практик, Улаанбаатар 2011

ХАВСРАЛТ – 1. ФОТО ЗУРАГ

2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Сэлэнгэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралаар "Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний ажлыг хэлэлцүүлэн, батлуулсан.